

ГҮНЗГИЙ МЭД

# MONGOLIAN ECONOMY

2015 оны 02 сар, № 04 (083)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

АВРАХ ГАРЦ


ЭДИЙН ЗАСАГ

Д.СУМЪЯАБАЗАР: ӨӨРӨӨ ӨӨРТЭЙГӨӨ, БОДОЖ БУЙ  
ЗҮЙЛТЭЙГЭЭ ЗӨРЧИЛДӨХ АСУУДЛУУД БАЙДАГ

БИЗНЕС

БИЗНЕСМЭНҮҮДИЙГ ӨМӨӨРӨХҮЙ

## “ITB BERLIN 2015” - МОНГОЛЫН БОЛОМЖ



## ӨДРИЙН БҮТЭЭМЖ 100%

1-д-2 ТАБЛЕТ,  
НОУТБУК НЭГ ДОР

БҮХ ТӨРЛИЙН  
ХОЛБОЛТУУД

ГАЙХАЛТАЙ  
ДИЗАЙН

ХҮЧИРХЭГ  
ҮЗҮҮЛЭЛТ



**Ажлаа ч хийнэ. Тоглоом ч тоглоно. Ямар ч хэрэглээнд тохирно.**

**Dell Inspiron 7000** серийн зөөврийн компьютерууд өдрийн турш таны бүхий л хэрэгцээг хангахаар зохион бүтээгдсэн.

Хүн бүрийн ажил болон хувийн амьдралын харьцаа өөр байдаг. Таны хэрэгцээнд 100% нийцэх загварыг та зөвхөн Dell-ээс сонгох боломжтой.



# ТА МӨНГӨНИЙ ЯАРАЛТАЙ ХЭРЭГЦЭЭГЭЭ ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭХИЙГ ХҮСЧ БАЙНА УУ?



Хүү (сарын): 1.8% (₮) 1.5% (\$, €)

Хэмжээ: Орлогын **70%-80%** хүртэл

Хугацаа: 12 сар

## ЗЭЭЛИЙН ЭРХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:  
Д.Бэхбаяр / 9999-4248  
Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:  
И.Отгонжаргал / 8800-6228  
СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:  
Б.Үүрийнтуяа  
Англи хэлний редактор:  
Ийланд Роберт Мэнн  
ВЭБ РЕДАКТОР:  
Б.Энхцэцэг  
Сэтгүүлчид:  
Б.Үүрийнтуяа  
Б.Энхцэцэг  
А.Бүрэнжаргал  
Г.Орхон  
Э.Зоригт  
Дизайнер:  
Ц.Энхтүвшин

Маркетингийн менежер:  
Д.Баранжав / 9409 2904  
Б.Наранцогт / 9409 2905

#### ХАЯГ

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.  
VI хороо, Их сургуулийн гудамж.  
AB center. 504 тоот  
15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/  
х-2762  
www.mongolianeconomy.mn  
info@mongolianeconomy.mn  
Утас/Факс: 976 - 7011 5476  
“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв  
www.ubprint.mn

#### Борлуулах цэгүүд:

“Интер ном”  
“Цэцэг төв”  
“Минж плаза”  
“Алтантүлхүүр” номын дэлгүүр  
“Номин” супермаркетийн бүх салбар  
“Макс” супермаркетийн бүх салбар  
“Фреско” супермаркет  
BTSI супермаркет  
“Аз орчлон” номын дэлгүүр  
“Билэг” их дэлгүүрийн номын тасаг  
“Гранд Плаза” дахь супермаркет  
“Мир” номын дэлгүүрийн  
“Grand plaza”  
“Metro mall”  
“Sky” супермаркет  
“Улаанбаатар” их дэлгүүр  
“Max mall” дэх салбарууд

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013  
оны Шилдэг сэтгүүл”

Монголын бизнесийн зөвлөлийн  
“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл  
мэдээллийн байгууллага - 2012”  
МҮХАУТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”



РЕДАКЦИА  
ЗАХИАЛБАЛ  
ХҮРГЭЛТ  
ҮНЭГҮЙ

## БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ

# 18.000₮

## ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

- 8 Аврах гарц
- 11 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын гурвалсан хөгжилд бодлогоо чиглүүлнэ
- 13 Хөгжлийн шаардлага
- 14 БНХАУ-ын аялал жуулчлалын өнөөгийн байдал
- 16 Аялсан хэвээр
- 18 Гаднын аяллын компаниудтай хамтрахад 4-5 жил шаардах нь ч бий
- 20 Хоёр дахь гэр болсон Монголын минь дурсамжууд
- 21 Адал явдлын зууч "Adventure Life"-ийн түүхээс

**ЭДИЙН ЗАСАГ**



- 22 Д.Сумъяабазар: Өөрөө өөртэйгөө, бодож буй зүйлтэйгээ зөрчилдөх асуудлууд байдаг

**БИЗНЕС**

- 27 Бизнесмэнүүдийг өмөөрөхүй
- 29 Тоон мэдээ
- 30 Янник Кугинер: Би Монголын цэлмэг, хөх тэнгэрт дуртай
- 34 ДАНШАРИ
- 35 Номын булан



Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай.

**ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН**

MongolianEconomy.mn/ дээр доорх **улаанаар тодруулсан** тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



**Б.Эрдэнэбат**

**Мэдлэг бол хүч ба Өвөр Монголоос төрсөн сэтгэгдэл**

Өвөр Монголын дөрвөн

том их сургуульд очиж урилгаар лекц уншив. Сайхан монголчуудтай танилцлаа. Монгол улсад Солонгосын соёлын нөлөө их болж байгаа. Харин Өвөр Монголд Монгол улсынх маш их байдаг юм байна. Бидний уран зохиол, урлаг - **mn/p/7176**

Ө.Ганзориг



**Хөшүүрэг**

Хүний үйл хөдлөлийг удирддаг Эдийн засгийн ба Философийн хөшүүргүүдийг өнөөдөр

авч үзье. Нэг талдаа Хүн буруу зүйлд амархан уруу татагддаг, залхуу, амин хувиа хичээсэн, аймхай амьтан. Гэхдээ хүнийг эдгээр зан чанарууд нь нээлт хийлгэж - **mn/p/7268**

Б.Дөлгөөн

**Хямралын гарц бол экспорт**


2015 оны босгон дээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ Монголын эдийн засаг хямарлаа гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Эдийн засгийн



тодорхойлолтын хувьд хоёр улирал дараалан эдийн засаг агшихыг хямрал гэж нэрлэдэг. Гэтэл 2014 оны арваннэгдүгээр сарын байдлаар - **mn/b/7292**

## Монгол

## Айлчлал



Монгол, Япон улсын хооронд эдийн засаг, худалдаа, санхүү, хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах боломжийг нээж буй “Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийг Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг аралын оронд хийсэн айлчлалынхаа үеэр үзэглэн баталгаажууллаа. Ингэснээр ирэх 10 жилд Японоос манай улсад нийлүүлэх 4500 куб см-ээс бага хөдөлгүүртэй автомашины импортод ногдуулдаг таван хувийн татварыг тэглэх нөхцөл бүрдэв. Түүнчлэн Японы тал Монгол Улсаас худалдан авах үхрийн боловсруулсан махны импортод татварын хөнгөлөлт үзүүлэх юм. Мөн Монгол Улсаас импортлох ноолуур, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг импортын татвараас чөлөөлөхөөр тохиролцсон байна.

## ОУВС



Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар Олон Улсын валютын сангийн төлөөлөгчид манай улсад албан ёсны айлчлал хийж

байна. Манай улсын зүгээс “Стэнд бай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар судалж буйг холбогдох албаныхан мэдээллээ. Энэ нь ОУВС-гаас ядуу, буурай эсвэл эдийн засаг нь уруудаж буй орнуудад богино хугацаанд санхүүгийн өндөр шаардлагатай, жилийн таван хувийн хүүтэй зээлийн хөтөлбөр юм. Хөтөлбөрийг 1-2 жилийн хугацаанд хэрэгжүүлдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд зээлийн хугацааг 36 сараас хэтрэхгүй байхаар заадаг байна. “Стэнд бай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр богино хугацааны зээл авч байгаа улсууд ОУВС-тай тодорхой асуудлаар тохиролцон Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулдаг аж.



## Найрсаг Улаанбаатар

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх чиг хандлагын баримт бичиг”-т тусгагдсаны дагуу “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр өнгөрсөн есдүгээр сард батлагдсан. Хөтөлбөрийг гурван үе шаттай хэрэгжүүлэх юм. Ингэснээр нийслэл хот 2020 онд хоёр сая жуулчин хүлээн авч, нийслэлийн эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хэмжээг 20 хувьд, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт ажиллагсдын тоог 35 мянгад хүргэхээр зорьж байгаа юм. “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн

хүрээнд аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, зохицуулалтыг оновчтой болгох, жуулчдын хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, бүх төрлийн үйлчилгээнд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж хотын соёлыг дэлгэрүүлэхэд чиглэсэн ажлууд хийж буй. Түүнчлэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүр нийслэлийн төсвийн таван хувийг зарцуулж байхаар НИТХ-аар шийдвэрлэжээ.



## Хөрөнгийн зах зээл

Монгол Улсын Хөрөнгийн бирж “Итгэмжлэгдсэн дилер”-ийн үйлчилгээг албан ёсоор нэвтрүүлсэн байна. Тус үйлчилгээ арилжааг илүү нээлттэй, идэвхтэй болгох зэрэг олон давуу талтай гэдгийг мэргэжилтнүүд онцоллоо. Энэхүү үйлчилгээ нь хөрөнгө оруулагчид болон иргэдэд хүссэн цагтаа үнэт цаасаа зарж борлуулах, зах зээлд чөлөөтэй хөрвүүлэх боломжийг олгох аж. Хөрөнгө оруулагчид итгэмжлэгдсэн дилерийн оролцоотойгоор Засгийн газраас тогтоогоод байгаа тогтмол хүүнд өөрчлөлт оруулах боломжтой бөгөөд эрэлтээс шалтгаалсан худалдах, худалдан авах, уян хатан хүүгийн нөхцөл бүрдэх давуу талтай юм байна.

## Ухаалаг хот



Нийслэлээс “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг 2020 он хүртэл хэрэгжүүлэхээр боловсруулсан. Хөтөлбөрийн зорилго нь цомхон бүтэцтэй, ойлгомжтой дүрэм журамтай, соёлтой шуурхай үйлчилгээ үзүүлэх ухаалаг хотыг бий болгоход оршиж буй. Энэ хүрээнд Ухаалаг засаглал, Ухаалаг эдийн засаг, Ухаалаг иргэд, Ухаалаг үйлчилгээ, Ухаалаг орчин болон Ухаалаг амьдрал гэсэн чиглэлээр хотын үйл ажиллагааг өөрчлөх зорилт дэвшүүлсэн. Түүнчлэн энэ хүрээнд Нийслэлийн Дата төвийн нууцлал хамгаалалтын системийг нэвтрүүлэх юм байна. Үүнд 280 сая төгрөг зарцуулж байгаа аж. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1.8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байгаа. Үүний 930 сая төгрөгийн төсөл арга хэмжээг энэ онд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

## Дэлхийн

## Хятадын эдийн засаг

Экспортын тогтворгүй өсөлт, багасч буй дотоодын хэрэгцээ, Засгийн газрын хөрөнгө оруулалтын бууралт болон орон сууцны зах зээлийн сулралт зэргээс үүдэн Хятадын эдийн засаг 2014 онд 7.4 хувийн



өсөлттэй гарсан нь сүүлийн 24 жилд гарсан хамгийн муу үзүүлэлт боллоо. Хятадын Төвбанкны Судалгааны албаны мэдээлснээр энэ жил эдийн засгийн өсөлт нь долоон хувь болж буурах магадлалтай аж. Эдийн засгийн уналтаас үүдэн компаниудын өрийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй, зогсонги байдалд орсноор банкны чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн эрсдэл дагуулж байна. Чанаргүй зээлийн хэмжээ өссөнөөр арилжааны банкууд хөрвөх чадвараа хянах шаардлагатай тулгарч болзошгүй тул хөрвөх чадвараа хангалттай хэмжээнд барихын тулд Төвбанк мөнгөний бодлогодоо зохицуулалт хийх шаардлагатай аж. Энэ нь Хятадын иргэд болон корпорациуд мөнгө гадагшаа ихээр шилжүүлж буй үетэй давхцаж байгаа бөгөөд Хятадын иргэд 72 тэрбум долларыг АНУ-д үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зарцуулжээ. Энэ нь жилийнхээс 72 хувиар өссөн үзүүлэлт юм.

### Орос батлан хамгаалах салбарын төсвөө нэмнэ

ОХУ-ын эдийн засаг буурсан, мөн барууны улсуудтай харилцах харилцаа хүндэрсэн хэдий ч Москва 10 гаруй жилийн турш төлөвлөсөн батлан хамгаалах салбарын шинэчлэлдээ 50 тэрбум

ам.доллар зарцуулахаар боллоо. Ингэснээр төсвийн зардал 30 хувиар нэмэгдэх юм. Оросын эдийн засаг 2015 онд өсөлт үзүүлэхгүй гэж буй ч тус улсын Ерөнхийлөгч Владимир Путин тус салбарын төсвийг баталлаа. Оросын Эдийн засгийн яамны сайд Алексей Улюкаев нэгдүгээр сард хийсэн мэдэгдэлдээ



“2015 онд ДНБ гурван хувиар буурах магадлалтай бөгөөд өмнө нь 7.5 хувиар өснө гэж тооцоолж байсан инфляци 12 хувь хүрэх төлөвтэй байна” гэжээ. Нэг баррель газрын тосны үнэ 50 ам.доллар хүрснээр гадагш чиглэх хөрөнгийн хэмжээ тэлсэн. Мөн Крымын халдлагыг эсэргүүцсэн АНУ болон Европын холбооны эдийн засгийн хориг арга хэмжээнээс үүдэн урьдчилсан тооцоонд өөрчлөлт орсон байна.

### Хөгжиж буй Энэтхэг



Хятадын эдийн засаг удааширч, Орос эдийн засгийн уналталд ороод байгаа энэ үед дэлхийн эдийн засгийн найдвар Энэтхэг улс болоод байна. Энэтхэгийн рупи дэлхийн хөрөнгийн биржүүд дээр улам өсөж, 10 хувиас буудаггүй байсан инфляци

тал хувиар буурч, үндэстэн дамнасан корпорациуд Энэтхэг дахь үйл ажиллагаагаа өргөтгөхөөр төлөвлөж байна. Энэтхэгийн эдийн засгийн өсөлт 2014 оны дөрөвдүгээр улирлын байдлаар өнгөрсөн жилээс 7.5 хувиар өссөн нь Хятадын өсөлтийг давсан үзүүлэлт болов. Энэхүү амжилт шинээр сонгогдсон Ерөнхий сайд Нарендра Модигийн ажлаа хүлээн авснаас хойш хэрэгжүүлсэн шинэ бодлогын үр дүн юм. Мөн мэдээллийн салбар, газрын тосны хямд өртөг болон үйлдвэрлэлийн салбарт оруулж буй гадаадын хөрөнгө оруулалт чухал нөлөө үзүүлж байна. Шинээр бизнес эрхлэх, импорт, экспортод хүндрэл учруулдаг хууль дүрмийг өөрчлөхийг Энэтхэгийн Засгийн газар хичээж байгаа. Дэлхийн банк Энэтхэг улсыг бизнес эрхлэхэд хамгийн хэцүү 189 улсын 142-т жагсаасан байна.

### “Рио Тинто”-гийн талаарх шинэ мэдээ

Дэлхий даяар ханшийн уналт нүүрлэж Оюутолгойн асуудал зогсонги байдалтай байгаа боловч Англи-Австралийн уул уурхайн томоохон компани “Рио Тинто” 6.5 тэрбум долларын цэвэр ашигтай ажилласан байна. Энэ нь өнгөрсөн жилийн үзүүлэлттэй харьцуулахад хоёр дахин өссөн тоо юм. “Рио Тинто” болон Монголын Засгийн газар хооронд удаан хугаацаны турш үргэлжилж буй ашиг хуваах маргаан Монголын эдийн засагт илүү хохиролтой тусаж буй аж. “Рио Тинто”-гийн эзэмшиж буй хувьцаа 2015 онд эрэлт ихтэй байна гэж шинжээчид үзэж байгаа.

Өнгөрсөн хоёрдугаар сард “Рио Тинто”-гийн ерөнхий захирал Сэм Валш Оюутолгойн асуудлаар мэдэгдэхдээ “Бид арваннэгдүгээр сард эцсийн саналаа хүргүүлсэн. Одоогийн байдлаар Монголын Засгийн газар саналыг хэлэлцэж байгаа. Бид төслийг үргэлжлүүлэх боломжтой болно гэж найдаж байна” гэжээ. Ерөнхий сайд Ч.Сайханбилэг дээрх асуудлыг 2015 оны хоёрдугаар хагас гэхэд эцэслэн шийдвэрлэх талаар санал гаргасныг Засгийн газар дэмжин баталжээ.

### Украйн



“Зүүн Украины асуудлыг намжаах хамгийн зөв шийдэл бол Минскийн гал зогсоох хэлэлцээр гарцаагүй мөн” хэмээн ОХУ-ын Ерөнхийлөгч Путин мэдэгджээ.

Оросын цэргүүд Украинд дайн өрнүүлж байна гэх мэдээллийг байгааг дахин няцаасан явдал боллоо.

“Дайны нөхцөлд байдалд хүрэх магадлал багатай гэж бодож байна. Тийм байдалд бүү хүрээсэй гэж найдаж байгаа. Европ, Оросын талууд аль аль нь Европын газар нутаг дээр зэвсэглэсэн мөргөлдөөн үүсгэхийг хүсэхгүй” гэжээ.

Мөн тэрбээр Минскийн хэлэлцээр хэрэгжиж эхэлвэл зүүн Украины байдал аажмаар намжина гэв. ■



Фотог Б.Бямба-Очир

Өнгөрсөн онд 400 мянга орчим жуулчин ирсэн гэх албан мэдээлэл байна.

## Аврах гарц

Б.Энхцэцэг

Одоогоос хорин жилийн өмнө Монголыг гаднынхан төдийлэн мэддэггүй байхад Голландын иргэн Рик /Rick Idema/ дэлхийг тойрох дугуйн аяллынхаа үеэр Монголыг дайрч өнгөрсөн бөгөөд “Миний амьдралдаа харсан хамгийн сайхан, онгон дагшин байгальтай газар юм” гэж тухайн үед хэлсэн байдаг. Тэрбээр өдгөө Монголд амьдардаг. Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод “Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгоно” гэж дурьджээ. Өнөөгийн байдлаар тус салбар тэрхүү өндөр уулын дөнгөж хормойд л зогсож буй.


Өнгөрсөн онд л гэхэд 400 мянга орчим жуулчин ирсэн гэх албан мэдээлэл байна. Гэхдээ энэ бол жуулчны виз авч орж ирж

буй бүх хүнийг хил дээр тоолсон тоо. Хятадын иргэд Монголд хууль бусаар ажиллах гэж ирэхдээ амарханаар нь жуулчны виз аваад ороод ирэх нь элбэг. Энэ хүмүүс дээрх 400 мянган жуулчны тоонд мөн багтдаг. Дээр нь Монголдоо хамгийн олон жуулчин хүлээж авдаг гэгддэг компаниуд тухайлбал, “Нью Жуулчин Турс” гэхэд хамгийн ихдээ 8-10 мянган жуулчин авдаг бол “Жуулчин” компаниар дамжиж 5-7 мянган жуулчин л ирдэг байна. Хоёр том компани нь нийлээд 20-хон мянган жуулчин аялуулж байхад бусад жижиг компани нийлээд үлдсэн 300 гаруй мянган жуулчинг хувааж авах уу даа. Тус салбарын хувийн хэвшлийнхэн Монголд нэг жилд ердөө 120-150 мянган гаднын иргэн л жинхэнэ утгаараа аялах гэж ирдэг гэж тооцоолдог.

Засгийн газраас “Монгол Улсыг зорих

жуулчдын тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна. 2015 он гэхэд манай улсад жилд нэг сая орчим гадны жуулчин ирдэг болно” хэмээн таван жилийн өмнө зарлаж байсан. Тэгвэл 2015 он болчихлоо. Зорьсон ёсоор бид нэг сая жуулчин энэ жил авах ёстой. Зөгнөл ёсоор өнгөрсөн жил авсан жуулчдын тоо энэ жил огцом буюу бараг 100 хувиар өсөх юм билээ. Хил хамгаалах ерөнхий газрын мэдээллээс үзэхэд Монголын аялал жуулчлалын салбарын өсөлт 2010 онд 10 хувь, 2011 онд ердөө 0.2 хувь, 2012 онд дөрвөн хувь байсан. Харин 2013 онд жуулчдын тоо өмнөх оноосоо бүр 12.2 хувиар буурсан бол өнгөрсөн онд 5.9 хувиар буурч 392 мянга болсон байгаа юм. /Хүснэгт 1/. Тэгвэл энэ жил нэг сая жуулчин авах нь юу л бол. Харин ирэх жилүүдэд боломж бий юу гэвэл

Аялал жуулчлалын салбарын өсөлт



Эх сурвалж: Аялал жуулчлалын үндэсний төв

мэдээж тийм. Гэвч аялал жуулчлалын салбарыг дэмжсэн дорвитой арга хэмжээнүүд авч, хүчтэй санаачлага, бодлого, стратеги барьж ажиллахгүй аваас хэдэн жилийн дараа өөрчлөгдсөн зүйлгүй, бахь байдгаараа 400 мянган жуулчинтайгаа сууж л байх болов уу.

Төрөөс тус салбарыг ойрын жилүүдэд овоо харж үзэх хандлагатай болсон. Соёл, спорт, аялал жуулчлалын яам байгуулагдснаас хойш нэг тэрбум гаруй төгрөгийг төрөөс 2013 онд тус салбарт төсөвлөсөн. Энэ нь урьд хожид аялал жуулчлалын салбарт үзэгдэж байгаагүй өндөр тоо. Өмнөх жилүүдэд нь 100-300хан сая төгрөгөөр аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг хэмжиж мөнгө хуваарилдаг байв. Өнгөрсөн жил бүр хоёр тэрбумыг төсөвлөсөн. Үүний зэрэгцээ Монгол олон улсын хэмжээний "ITB Berlin" аялал жуулчлалын үзэсгэлэнд 2015 онд түншээр оролцохоор болж, 18 тэрбумыг төсөвлөсөн явдал нь тус салбарын түүхэнд байгаагүй олон оронтой тоо билээ.

**"International Tourism Boerse 2015" ба ҮР ДҮН**

Энэ гуравдугаар сард бид Берлин хотноо "International Tourism Boerse 2015 /ITB/" олон улсын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэнд "Монгол, Язгуурын нүүдэлчид" гэх дүр төрхтэйгээр түнш орноор оролцож, Монголыгоо сурталчилна. Энэ бол Төрийн аялал жуулчлалын салбарт гаргасан хамгийн том бөгөөд анхны шийдвэртэй алхам, өндөр санхүүжилт.

Тус үзэсгэлэнд 2012 онд түнш орноор оролцож байсан Турк улсын хувьд өнгөрсөн оныг хүртэл хүлээн

авсан жуулчдын тоо 50 орчим хувиар өссөн байдаг. Гэвч тус улсын дэд бүтэц өндөр хөгжсөн, төрийн аялал жуулчлалд үзүүлэх бодлогын дэмжлэг сайн гэдгийг харгалзаж үзэх нь зүйтэй. Харин 2011 онд түнш орноор оролцсон Польшийн аялал жуулчлал удаах жилд нь 11 хувиар өсчээ. БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Мурат Карагөз "ITB-д оролцох нь Монголд томоохон сурталчилгаа, боломж, алсын хараа болж өгөх нь дамжиггүй. Гэвч Монголын аялал жуулчлалын ирээдүйн хөгжилд хангалттай дэмжлэг мөн үү гэвэл мэдээж үгүй. Аялал жуулчлалыг дэмжсэн маш сайн стратегийг үргэлжүүлэн барьж байж дээрх арга хэмжээнд оролцсоны үр дүн гарна" хэмээн хэлж байна. Турк улс "ITB" үзэсгэлэнд оролцсоныхоо дараа дэлхийд хамгийн олон жуулчин ирдэг улсууд дундаа зургаадугаарт орох болж, Европтоо дөрөвдүгээрт бичигдэх болсон билээ.

"Бидэнд 2016 он гэхэд хамгийн багадаа нэг сая жуулчин хүлээн авна гэсэн тооцоо бий. Энэ бол зөвхөн "ITB-Berlin" -ээс гарах үр дүн биш. Тус үзэсгэлэн бол хүчтэй эхлэл тавьж өгч буй суурь. Тэгэхээр үүний дараа үр дүн хүлээгээд суух бус боломж байвал 2016 оныг төрөөс Монголд зочлох жил болгон зарлаж, аялал жуулчлалд чиглэсэн бодлогоо тууштай хэдэн жил барих хэрэгтэй. Олон цогц менежментийн асуудлыг шийдэж чадвал "ITB"-ээс үр дүн гарна." гэж Аялал жуулчлал-Ирээдүй ТББ-ын захирал Б.Индраа хэллээ.

Бидэнд тус үзэсгэлэнд 2011 онд Соёлын түнш орноор оролцсон удаа бий. Тухайн үед соёл урлагийг аялал жуулчлалтай уялдуулж, Монголыг зорилтот зах зээлд өөр өнцгөөс нь харуулж чадсан. Тиймээс ч Засгийн газар түнш орноор оролцох том шийдвэрийг тэр жил гаргаж, улсын төсвөөс 18 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно гэж Н.Алтанхуяг Ерөнхий сайд асан амласан байдаг. Төр энэ мөнгөө бүрэн бүтэн өгөөгүйг эс тооцвол аялал жуулчлалын салбарыг анх удаа онцгой анхаарч, гойд их санхүүжилт хийж буй. Амласан

санхүүжилт эдийн засаг хүндэрч, Засгийн газар солигдсон энэ үед хоёр дахин буурч долоон тэрбум руу уруудчихсан. Арга бараад хандивын арга хэмжээ зохион байгуулж, санхүүжилт босгох дээрээ хүртэл тулсаныг зохион байгуулагчдын зүгээс учирласан. Төсөв тарчиг болсон ч байгаа мөнгөндөө тааруулаад хийх ёстой зарим ажлаа хасаад ямартай ч оролцоно.

Салбарын зарим оролцогч "ITB Berlin-2015"-д түншээр оролцох болсныг хий дэмий мөнгө салхинд хийсгэж байна гэж үзэж байна. Өнгөрсөн хугацаанд тус үзэсгэлэнд манай томоохон долоон аяллын компани тогтмол оролцож ирсэн байдаг. Тэдний хувьд нэг удаадаа 20-30 сая төгрөгийн зардал гаргаж тус үзэсгэлэнд оролцсоор ирсэн. Тэд мөнгө нь илүүдсэндээ үргэлж "ITB"-д оролцдоггүй гэдгээ хэлж буй. "Компаниуд тус үзэсгэлэнд шинэ түншүүдтэй болохын зэрэгцээ хамтарч ажилладаг түншүүдтэйгээ уулзаж өнгөрсөн оныхоо ажлыг дүгнэж, ирэх 2-3 жилд хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцах гэж оролцдог" хэмээн үзэсгэлэнд оролцохоор зэхэж буй 18 компанийн нэг "Нью Жуулчин Турс" компанийн ерөнхий менежер Д.Наранцэцэг хэлж байна. Гаднын зарим компанитай шууд "ITB" дээр хамтран ажиллах гэрээ хийх тохиолдол бий ч Монголын талаарх мэдээлэл дутмагаас ихэнх компани олон жил судалсны эцэст монголчуудтай гэрээ хийдэг байна.

Монголын аялал жуулчлалын салбарынхны "ITB-Berlin 2015"-ээс хүлээж буй гол хүлээлт нь олон улсад сайн танигдах, тэдэнд ойлголт өгөх аж. Ер нь Монголын тухай мэдээлэл олон улсад маш бага байдаг. Европт тухайлбал, Монголыг сурталчилж, аяллын багц гаргадаг хэдхэн компани мэдээлэлтэй байдгаас биш энгийн иргэдийнх нь хувьд тодорхой ойлголт байдаггүй талаар Европт түнштэй дотоодын аяллын компаниуд хэлдэг. Энэ нь Монголыг олон улсад илтгэсэн тодорхой имиж байдаггүйтэй холбоотой. Монголд аялсан Ричард Гир, Жулиа Робертс, Еван Магрегор зэрэг алдартан төдийгүй бие даасан аялагчид манай улсыг сүүлийн таван жил олон улсад нэлээд сайн сурталчиллаа. Тухайлбал, Жак Вэйдэрфордын Чингис хааны тухай түүхэн зохиол Хойд америкчуудын

# МОНГОЛ УЛСЫГ ЗОРИХ ЖУУЛЧДЫН ТОО

2012



475,783



**\$286'500'000**  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО  
**\$602**  
НЭГ ЖУУЛЧИНЫ ЗАРЦУУЛАЛТ

2014



400,000



**1'000'000** жуулчин ирснээр нэг хүнд ноогдох ДНБ болон өрхийн дундаж орлого ойролцоогоор 10%-аар өснө.

2016



1,000,000



**\$1'000'000'000**  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО  
**\$1'000**  
НЭГ ЖУУЛЧИНЫ ЗАРЦУУЛАЛТ  
**1** ЖУУЛЧИН ДУНДЖААР  
**5** ХОНОГ АЯЛАНА.



**2'000'000**  
литр сүү  
Өдөрт **400** гр сүү



**1'000**  
тонн мах  
Өдөрт **200** гр мах



**28'000**  
Зөөгч



**7'000**  
Тогооч



**3'000**  
Таксины жолооч

Эх сурвалж: Аялал жуулчлал-Ирээдүй ТББ

анхаарлыг Монгол руу татсан гэдэг. “Хувьсгалын тохироо бүрдсэн мэт зориудын бус нөхцөл байдал, өгөгдлүүд Монголын аялал жуулчлалын салбарыг дэлхий дахинд нэлээд сайн танилцуулж ирлээ. Өнөөдрийг хүртэл Монгол улсын сурталчилгааг тууштай системтэй хийгээгүй болохоор бид уламжлалт зах зээлийнхээ боломж, нөөцийг шавхаж тултал нь гаргаж ирээгүй” гэж Б.Индраа хэлж байна.

Мөн тэрбээр “Мэргэжлийн зах зээл дээр Монголыг хэрхэн гаргаж ирж, олон

улсын компаниудтай аяллын гэрээг олноор нь хийх вэ гэдгийг шийдвэрлэх шат руу орох цаг нь болсон. Өнөөдөр “ITB”-д оролцсоноор цэвэр мэргэжлийн зах зээлд олон улсын түншүүдтэй хамтын ажиллагаа байгуулах, бэхжүүлэх боломж ирнэ” хэмээсэн юм. Өнөөдөр манай улсын дүр төрх гаднын орнуудад ихээхэн гундуу болчихсон. Сүүлийн жилүүдэд уул уурхайн томоохон төслүүдтэй холбогдсон маргаан, хөрөнгө оруулалтын тогтворгүй орчноос үүдэн дэлхий дахинд бий болсон, Монголын талаарх сөрөг

ойлголтыг засч залруулах сорилттой бид тулгарчихаад байна. Энэхүү имижийг өөрчилж, Монгол найрсаг, байгаль орчноо хамгаалдаг орон хэвээр гэдгийг ойлгуулах том боломж бол “ITB Berlin 2015” үзэсгэлэн. Ирэх жил гэхэд манай улс нэг сая жуулчин хүлээн авч, үүний үр дүнд нэг тэрбум төгрөгийн орлого олох зорилттой байгаа. Хэдийгээр уул уурхайгаас орж ирж буй орлогыг гүйцэхгүй ч аялал жуулчлал бол валют ордог салбар. Уул уурхай сөхрөхөд авраг гарц болох бүрэн чадамжтай салбар. ■



Фотог Б.Бямба-Очир

БОНХАЖ-ын сайд Д.Оюунхорол нь одоогийн албан тушаалаа хүлээн аваад хоёр сар гаруй хугацаа өнгөрч байна.

Бодлого

## Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын гурвалсан хөгжилд бодлогоо чиглүүлнэ

Б.Цэцээ

*Аялал жуулчлалын салбарыг Соёл, спортоос салгаж, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай нэгтгэсэн билээ. Тиймээс бид БОНХАЖ-ын сайд Д.Оюунхоролоос тус салбарын цаашдын хувь заяа хэрхэх, “ITB” аялал жуулчлалын дэлхийн хамгийн том үзэсгэлэнд Монгол улс түнш орноор оролцохын өгөөж юу байх талаар ярилцсан юм.*

**-Аялал жуулчлалын салбар нэг яамны халааснаас нөгөө рүү байнга шилждэг үйл явцыг аялал жуулчлалыг үйлдвэрлэлийн салбар гэж үзэхгүй байна гэх дүгнэлтэд хүргэж байна. Эдийн засгийн ач холбогдлынх нь үүднээс та аялал жуулчлалыг хэрхэн харж байна?**

-Мэдээж аялал жуулчлалын салбарыг нэг яамнаас нөгөө рүү шилжүүлээд байгаа нь зөв алхам биш. Учир нь

бодлогын залгамж халаа алдагдахаас эхлээд сөрөг тал их. Гэхдээ Монгол оронд аялал жуулчлалын салбар байгаль орчин, ногоон хөгжлийн салбартайгаа нэгдэн ажиллах нь хамгийн зөв шийдэл гэж хардаг. Дэлхийн жишгийг харахад Энэтхэг, Гана зэрэг цөөн оронд аялал жуулчлалын салбар нь дангаараа яамтай байдаг юм билээ. Дэлхийн олон оронд дэд бүтэц, агаарын тээвэр, аж

үйлдвэр, байгаль орчин, соёлын аль нэг салбартай хамтдаа байж хослон хөгждөг юм байна. Дэлхий дахинд жуулчлалаар зорих газар, чиглэлүүд нэмэгдэж, хөрөнгө оруулалт ч жилээс жилд өссөөр ирсэн. Аялал жуулчлалын экспорт нь дэлхийн нийт зах зээлийн үйлчилгээний экспортын 30 хувь, нийт бараа, үйлчилгээний экспортын зургаан хувийг эзэлдэг гэсэн хамгийн сүүлийн үеийн дүн гарчээ. Ялангуяа манайх шиг хөгжиж буй орнуудын хувьд аялал жуулчлал гадаад худалдааны орлого, экспортын гол эх үүсвэр болж байна. Тийм учраас утаагүй үйлдвэрлэл гэгддэг аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлснээр эдийн засагт үзүүлэх үр өгөөж урт хугацаанд өсөн нэмэгдэх болно.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хүргэж, хамгаалалтад авах учиртай тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг бид чухалчлан авч үзэж байна. Байгалийн үзэсгэлэнт, дахин давтагдашгүй өвөрмөц тогтоцтой, ховор, ховордсон амьтан, ургамлын гол

тархац, түүх соёлын дурсгалт газрууд нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн хамгийн үнэ цэнэтэй хэсэг учраас аялал жуулчлалын гол түшиц бааз гэж хэлж болох юм. Манай улсын аялал жуулчлалын бүс нутгийн 85 хувь, жуулчны баазуудын 75 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсүүдэд харьяалагдаж байна.

**-Танай яамны зүгээс аялал жуулчлалын салбарт өмнө нь барьж байсан бодлогод ямар өөрчлөлт, нэмэлтүүд оруулж байна вэ?**

-Ямар ч үед төрийн бодлогын залгамж чанар гэж байдаг. Бид түүнийг л баримталж ажиллана. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тодорхой зорилтууд тусгагдсан байгаа. Тухайлбал, аялал жуулчлалын салбарын бодлогыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн төрлүүдээр, түүний дотор тусгай сонирхлын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлэхээр Засгийн газрын хөтөлбөрт туссан. Мөн Монгол орны хангайн бүс нутгийн байгалийн унаган төрхийг хэвээр хадгалан аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх, аялал жуулчлалын дэд бүтэц, барилга, байгууламжийг барьж байгуулах, Монгол руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлэх гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Тэр дундаа энэ салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор бид эрчимтэй ажиллаж эхлээд байна. Аялал жуулчлалын тухай хууль болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах, аялал жуулчлалын салбарын гадаад сурталчилгааны маркетинг төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Казиногийн тухай болон Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барих ажлыг хийж байна. Ер нь уул уурхайн хөрөнгө оруулалт зогссон, эдийн засаг хямралтай байгаа үед аялал жуулчлалдаа онцгой анхаарах хэрэгтэй гэсэн олон улсын байгууллагын зөвлөмж ч бий. Тийм учраас байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын гурвалсан хөгжилд бодлогоо чиглүүлж

ажиллаж байна.

**-Байгаль орчин, ногоон хөгжлийн салбартай аялал жуулчлалыг хамтатгаснаас үүдэн хариуцлагатай аялал жуулчлалыг түлхүү анхаарч ажиллах болов уу гэсэн хүлээлт байна. Тэгвэл энэ чигийг хэрхэн тодорхойлж, хариуцлагыг тооцох вэ?**

-Хариуцлагатай аялал жуулчлал гэж сайн үйлчилгээ авч, тухтай амрах гэж ирсэн жуулчдыг бүх талаар тав тухтай байлгаж, сэтгэл дүүрэн буцаахыг хэлэх болов уу гэж бодож байна. Аялал жуулчлалын салбарын цаашдын хөгжил аялж жуулчлахаар ирсэн хүмүүсийн эрэлт, хэрэгцээг хэр хангаж байгаагаас шалтгаалах байх. Тийм учраас орон нутагт аялал жуулчлалын салбарыг бэхжүүлэх гэвэл төрөөс үзүүлэх үйлчилгээ, ялангуяа дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах шаардлага тулгарч байна. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар аялал жуулчлалын салбараар дамжуулан орон нутгийн ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллах ёстой гэж ойлгож, энэ чиглэлд бодлого боловсруулж байна. Энэ салбарын нэр хүнд олон улсад асар их өсч байлаа. Үнэхээр сайн хөгжүүлж чадвал байгаль орчиндоо ч ээлтэй, үнэхээр л “Утаагүй үйлдвэрлэлийг” бий болгож чадна. Аялал жуулчлалыг дэлхий нийтээр “Ард түмнүүдийн найрамдал, хамтын ажиллагааг идэвхжүүлэгч”, “Утаагүй үйлдвэрлэл”, “Үл үзэгдэгч экспорт” гэж нэрлэж, зүй ёсоор үнэлэх боллоо. Монголын хувьд энэ салбар хөдөө аж ахуй, уул уурхайн дараа орох эдийн засгийн гурав дахь чухал салбар. 2012 оны байдлаар Монголын ДНБ-д аялал жуулчлалын салбарын эзлэх хувь дөрвөн хувь, нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь 13 болсон байна.

**-Монгол Улс ирэх жил гэхэд нэг сая жуулчин авна гэсэн том зорилттойгоор “ITB Berlin-2015” үзэсгэлэнд оролцох гэж байна. Салбарын яамны зүгээс энэ үзэсгэлэнд ямар үүрэг, оролцоотой оролцож байна вэ?**

-Монгол Улс 2000 оноос хойш “ITB Berlin” хэмээх дэлхийн аялал жуулчлалын салбарын хамгийн том үзэсгэлэнд 14 жил дараалан оролцсон. Энэ онд түнш орноор оролцох Засгийн газрын шийдвэр гарсан. Үүгээрээ Монголын төр аялал

жуулчлалын салбарт урьд өмнө нь оруулж байгаагүй томоохон хөрөнгө оруулалтыг “ITB Berlin” үзэсгэлэнгээр дамжуулан хийж байна гэж ойлгож болно. Үзэсгэлэнгийн үеэр хамгийн гол нь жуулчдын зорин очих орны нэг бол Монгол гэсэн мессежийг дэлхий нийтэд өгөх учраас аялал жуулчлалын бизнесээс ашиг орлого олдог, энэ салбарт хамаардаг төрийн болон төрийн бус байгууллагууд, хүн бүрийн хувьд 2015, 2016 он маш чухал жилүүд байх болно. Уул уурхайн салбартай дүйцэхүйц, өрсөлдөхүйц орлого олж, эдийн засгийг солонгоруулах, энэ салбарыг илүү өндөр түвшинд гаргах гэсэн тодорхой бодлогын үүднээс манай улсын Засгийн газар энэ үзэсгэлэнд түнш орноор оролцохыг дэмжсэн. Бид аялал жуулчлалын салбарыг тогтвортой хөгжүүлэхээр “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлж батлуулахад бэлэн болоод байна. Тус хөтөлбөрт Монголд ирэх жуулчдын тоог 2016 он гэхэд нэг сая, 2020 он гэхэд хоёр саяд хүргэх зорилт тавьсан. Нөгөө талаар энэ салбарын хөгжлийг ирж байгаа жуулчдын тоогоор төдийгүй олон улсад өрсөлдөх чадварын индексээр хэмждэг. Монгол Улс 2013 оны байдлаар энэ индексээр 140 орноос 99-т жагссан бол 2017 он гэхэд 90-д, 2020 он гэхэд 80 дугаар байранд хүрэх зорилт тавьсан. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээг үндэсний хөтөлбөртөө тусгаад ажиллаж байна.

**-Тус салбарт дагалдах ээлтэй бодлого, зохицуулалтуудыг хийж байж “ITB” үзэсгэлэнд оролцсоны үр дүн гарна гэж “ITB”-гийн зохион байгуулагчид үзэж байгаа. Тэгвэл ирэх жилүүдэд аялал жуулчлалын дэмжсэн, салбарынханд ээлтэй ямар санаачлага, бодлого, зохицуулалтыг барьж ажиллах вэ?**

-“ITB Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд амжилттай оролцсоноор дараагийн 1-2 жилээс эхлэн ирэх жуулчдын тоо нь нэмэгддэг гэдгийг өмнө нь оролцож байсан улсуудын жишээнээс харж болно. “Саалиа бэлдэхээр саваа бэлд” гэж бид ярьдаг. Үзэсгэлэнд оролцсоноор өмнөхөөс хавьгүй олон жуулчин ирнэ гэж итгэж байна. Гэхдээ манай дэд бүтэц, жуулчны тээвэрлэх хүчин чадал, тур операторууд, зочид буудал, жуулчны бааз, ресторан

хоолны газар, жуулчдын мэдээллийн төв, хөтөч тайлбарлагч, таксины жолооч гээд энэ салбараас ашиг орлого олдог бүх тал энэ салбартаа үйлчлэхэд бэлэн эсэхийг нягталж цэгцлэх шаардлагатай гэж үзэж байгаа. Тэрчлэн жуулчдын аюулгүй байдлыг хангах талаар Засгийн газраас илүү анхаарал тавин ажиллах болно.

Дээр дурьдсанчлан, бид салбарын эрх зүйн орчныг шинэчлэх, зочлохуйн үйлчилгээний салбарын чадавхыг сайжруулах, хөтөч тайлбарлагч нарын мэргэжил дээшлүүлэх, Улаанбаатар хот дахь мэдээллийн төвүүдийг нэмж ажиллуулах, хөдөө орон нутагт жуулчны гол маршрутын чиглэл дагуу зүг чигийн самбар, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах зэрэг ажлыг хийхээр төлөвлөн, түрүүчээс

нь эхлүүлээд байна.

**-Манай улсын аялал жуулчлалын салбарын үнийн өрсөлдөх чадвар бусад улстай харьцуулахад нэлээд сул. Үнэдээ нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж чадахгүй байна гэх гомдол олон ирдэг. Тэгвэл яамны зүгээс үүн дээр хэрхэн анхаарч ажиллах вэ?**

-Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр Монгол Улс 140 орноос 99-т эрэмбэлэгдэж байгааг дээр хэлсэн. Гэтэл яг үнийн өрсөлдөх чадварын үзүүлэлт гэхээр 140 орноос 36 дугаар байранд орсон байна. Харин байгаль орчны тогтвортой байдал, тээврийн болон аялал жуулчлалын дэд бүтцийн үзүүлэлтээр 135-137 дугаарт

эрэмбэлэгддэг юм байна. Үүнээс харахад бид өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд аяллын үнэ, өртөгт гол анхаарлаа хандуулах бус бусад холбогдох салбартай аялал жуулчлалыг хэрхэн уялдуулан хөгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

Аялал жуулчлалын салбар маань бусад олон салбараас хамааралтай бөгөөд салбар дундын зохицуулалт шаардсан онцгой салбар байдаг. Тиймээс тус салбарын хөгжлийг эрчимжүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаануудыг дээр дурьдсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөртөө” тусгасан. Хөтөлбөр удахгүй батлагдана. ■

Үзэл бодол

## Хөгжлийн шаардлага

Ё.Ундраа /“Жуулчин” компанийн гүйцэтгэх захирал/



Аялал жуулчлал бол маш өргөн Ацар хүрээг хамардаг бизнесийн салбар. Нэг багц аялал зохион байгуулахад л зочид буудал, ресторан, үзвэр, үйлчилгээний байгууллагууд, худалдаа, тээвэр гэх мэт олон салбарын үйл ажиллагаа идэвхжиж байдаг. Ийм учраас олон улсууд аялал жуулчлалыг эдийн засгийн тулгуур салбар болгодог. Ингэснээр бусад салбарынхаа үйл ажиллагааг тэтгэж дэмжих, эргээд эдийн засгийн үр ашгийг нь хүртэнэ гэсэн цикл бий болдог.

Манай улсын хувьд аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болгох зорилтыг аль хэдийн тавьсан. Гэсэн ч ДНБ-ий дөрвөн хувьд ч хүрэхгүй жижиг хэвээр байна. Тус салбарын өсөлтийг хангах нэг гарц бол үндэсний томоохон

компаниудыг бий болгох явдал. Өнөөдөр аялал жуулчлалын салбарыг бүрдүүлж буй компаниуд хэт жижиг, өрхийн аж ахуйг хангахад чиглэсэн, санхүүгийн үйл ажиллагаа нь нууцлагдмал, тогтмол ажлын байр бий болгож чаддаггүй зэрэг олон дутагдал бий. Эдгээрийг арилгах нэг хөшүүрэг бол жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, тэр дундаа хөрш орнуудын жуулчдын урсгалыг эрчимчүүлэх замаар компаниудын үйл ажиллагааг тогтворжуулах, чадваржуулах явдал гэж харж байна.

Аливаа улсын эдийн засагт хөрш орнуудын нөлөө их байдаг. Эл жишгээр аялал жуулчлалын салбарт хөрш орноос ирэх жуулчдын тоо гол нөлөө үзүүлдэг. Монгол Улсын хувьд эдийн засаг нь эрчимтэй хөгжиж байгаа, хүн ам ихтэй орнууд мөн урд, хойд хөршүүд нь дунд

хугацаанд потенциал (боломжит) бүс нутгууд болно. Эдгээр орноос ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхийн тулд хилийн бүсийн хотуудыг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх, тэдгээр гол бүс рүү болон Улаанбаатар хот руу чиглэх орон нутгийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, олон улсын нислэг хийх хотын тоог нэмэгдүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.

Аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөдөлгөгч хүч болох үндэсний томоохон компаниудыг бий болгоход хөрш орнууд, түүний дотор дэлхий нийтийн анхаарлын төвд ороод байгаа БНХАУ-ын жуулчдыг татах, тус улсын аялал жуулчлалын салбарын хандлагаас суралцах явдал бидний зайлшгүй хийх нэг алхам. ■



Хятад

## БНХАУ-ын аялал жуулчлалын өнөөгийн байдал

Улсынхаа бусад салбартай хамтран ажилласнаар эдийн засгаа хэрхэн хөшүүрэгдэж болох, улмаар хөгжлийн чиг хандлагад ямар чухал нөлөө үзүүлж болдогийг Хятад улс сүүлийн жилүүдэд тод харуулж байна.

Хятадын Шинэ хувьсгалаас буюу 1978 оноос хойш БНХАУ-ын Засгийн газар аялал жуулчлалын салбартаа ихээхэн анхаарал хандуулж эдийн засгийнхаа гурав дахь тулгуур салбар болгохоор төлөвлөж ажилласан байдаг. 2002 оноос эхлэн тус улсын дотоод аялал хурдацтай нэмэгдэж эхэлсэн бол сүүлийн жилүүдэд гадаад улс орнууд руу аялах хятад жуулчид эрс нэмэгдэх болсон. Хятад дэлхийн олон оронтой найрсаг харилцаа тогтоон, тэдний туршлагаас суралцахын зэрэгцээ аялал жуулчлалын салбартаа өөрсдийн өв соёл, зан заншлын онцлогийг тусган ажиллаж байна. Үүнээс гадна Хятадыг зорих жуулчдын визний асуудалд уян хатан бодлогоор хандаж байгаа нь аялал жуулчлалд том хувь нэмэр оруулж байгаа юм. Тухайлбал, гадаадын иргэд Шанхай хотод 48 цаг, Хайнанд 15 өдрийн визгүй зорчдог. Түүнчлэн Бээжин, Шанхай, Гуанжу гэх мэт хотуудын 145, баруун бүсийн 100

гаруй том, жижиг онгоцны буудлууд, тэдгээрээс санал болгож буй шууд нислэгүүд ч томоохон нөлөө үзүүлж байгаа. Жуулчдын хамгийн их зорчдог 28 бүс нутгаас нэрлэхэд нийслэл Бээжин хот, Шанхай, Тианжин, Далиан, Шиамэн, Ши ан, Гүйлин, Ханжөү, Шөнжөн, Күнмин, Саняа, Чиндао, Нанжин, Янтай зэрэг эдийн засаг, хөгжлийн төв болсон орчин үеийн томоохон хотууд төдийгүй уламжлалт өв соёлоо хадгалан хөгжиж буй эртний хотууд салбарын хөгжлийн хөшүүрэг болдог. Хятадын ард түмэн дэлхийн стандартад нийцсэн өндөр зэрэглэлийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ өөрсдийн уламжлалт зан үйл, өв соёлоо сурталчилан таниулж байгааг бид харж байна.

2001-2008 онуудад зохион байгуулагдсан тив, дэлхийн хэмжээний урлаг, спортын уралдаан тэмцээнүүд нь Хятад улсыг дэлхий нийтэд зарлан тунхагласан гэж болох. Улмаар дэлхийн саяа сая жуулчдын аяллын төлөвлөгөөнд багтах том гүрэн болж чадсан. Үүний томоохон жишээ бол тус улсад зохион байгуулагдсан 2008 оны Зуны олимп билээ. БНХАУ-д аялсан жуулчдын тоонд Япон, Солонгос, ОХУ, Малайз, Филиппин,

Сингапур, Тайланд, АНУ, Англи зэрэг орны жуулчид тэргүүлж байна.

Хятадын Засгийн газар аялал жуулчлалын салбараа жил бүр долоон хувийн өсөлттэй байлгахыг зорьдог. 2013 оны байдлаар Хятадыг зорьсон жуулчдын тоо өмнөх оныхтой харьцуулахад 10 хувиар, салбарын нийт орлого 2012 онтой харьцуулахад 12 хувиар тус тус өссөн. Түүнчлэн тус улсын Засгийн газрын тооцоолж буйгаар 2020 он гэхэд тус улс руу аялах гадаад жуулчдыг 200 саяд хүргэх, улмаар салбарын орлогыг 850 их наяд ам.долларт хүргэхээр ажиллаж буй. Энэ нь Хятадын ДНБ-ий 11 хувьтай тэнцэх юм. Тийм учраас 2020 он хүртэлх хугацааг Хятад улсын аялал жуулчлалын алтан цаг үе гэж нэрлэжээ.

Бүх Хятадын аялал жуулчлалын газраас энэ оны нэгдүгээр сарын 15, 16-нд зохион байгуулсан Их хурлаар 2015 оны аялал жуулчлалын чиг хандлага, өсөлт бууралтыг нэгтгэн мэдээлэл хийсэн бөгөөд дотоод аялагчдын тоог 39.5 сая, гадагшаа аялагчдын тоог 10 хувиар нэмэгдүүлж 2.48 саяд хүргэнэ гэж төлөвлөж буйгаа мэдээлсэн. ■



## Олон улсын II түвшиний стандартад нийцсэн ХААН БАНКНЫ ДАТА ТӨВ



АНУ-д төвтэй Аптайм Институт (Uptime Institute) нь Дата Төвүүдэд гэрчилгээ олгодог олон улсын эрх бүхий байгууллага бөгөөд ХААН Банкны зүгээс өөрийн Үндсэн Дата Төвийнхөө шийдэл, загвар, дизайн, байгууламж/суурилуулалт зэргийг шалгуулахаар Аптайм Институтийг урьж, ажиллуулсан юм.

Өнгөрсөн 2014 оны 8-р сард Аптайм Институтээс ХААН Банкны Үндсэн Дата Төвийн шийдэл, загвар, дизайн нь олон улсын стандартын 2-р түвшиний дата төвийн шаардлагад нийцсэн болохыг баталж, гэрчилгээ олгосон бол 2015 оны 1-р сард тус институтээс дахин олон улсын стандартын 2-р түвшинд нийцсэн байгууламж, суурилуулалт хийгдсэн болохыг баталж, гэрчилгээг олголоо.

Эдгээр гэрчилгээг хүлээн авсанаар ХААН Банкны Үндсэн Дата Төв нь Аптайм Институтээс гэрчилгээ авсан Монгол улсын анхны бөгөөд цор ганц Дата төв болж байгаа юм.

Олон улсад Дата Төвүүдийг тодорхой шалгуурын дагуу 4 түвшинд ангилж үздэг. Эхний хоёр түвшиний дата төвүүдийн хувьд дараах стандартад байдаг байна.

Үүнд:

### Нэгдүгээр түвшин

- Мэдээлэл технологийн тоног төхөөрөмжүүдийн харилцан холболт ямар нэг нөөцгүй буюу дан холболттой. Мөн дэд бүтцийн хүчин чадал, бүрдэл бүхий тоног төхөөрөмж, байгууламжууд нь нөөцгүй (backup-гүй).

### Хоёрдугаар түвшин

- Нэгдүгээр түвшиний шаардлагуудыг давж биелүүлсэн,
- 99.741%-ийн бэлэн байдалтай, дэд бүтцийн хүчин чадал, бүрдэл бүхий тоног төхөөрөмж, байгууламжууд нь нөөцтэй (backup-тай).

ХААН Банкны хувьд 2-р түвшиний Дата Төвийн шийдэл, загвар дизайныг гаргах, барьж байгуулах, гэрчилгээ авах ажил 2012 оноос эхэлсэн бөгөөд олон улсын зөвлөх, мэргэжилтнүүд, архитектор, инженерүүдтэй хамтран ажиллаж, загварыг боловсруулан, тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилга байгууламж зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажил болсон юм.

Үндсэн Дата Төвийн дэд бүтэц 99.741%-ийн бүрэн ажиллагаатай байна. Улмаар гадаад орчны нөлөөлөл, томоохон осол гэх мэт үүсч болох олон төрлийн гэмтэл, саатал гарсан үед Дата Төвийн цахилгаан, эрчим хүч, хөргүүр зэрэг нь найдвартай ажиллахыг баталгаажуулж байгаа юм.

ХААН Банк нь харилцагчиддаа хамгийн өндөр түвшиний бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийн төлөө үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажилладагийн нэгэн тод жишээ энэ юм. Ийнхүү олон улсын стандартад нийцсэн Дата Төвийг барихад томоохон хөрөнгө оруулалт хийн ашиглалтад оруулан дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ авсанаар ХААН Банкны харилцагчид найдвартай, тасралтгүй үйлчилгээ авах боломжоор хангагдаж буй юм.

Та бүхэн доорх холбоосоор Аптайм Институтын албан ёсны цахим хуудсанд хандан Монгол улсыг сонгон гэрчилгээг харах боломжтой.

<https://uptimeinstitute.com/TierCertification/certMaps.php>



Орос

Э.Баттулга  
/Нийслэлийн аялал жуулчлалын газрын дарга/

ОХУ-Украины хямрал, түүнээс үүдэн ОХУ-ын эсрэг Европын холбооноос авсан эдийн засгийн хориг арга хэмжээ Европын аялал жуулчлалд сөргөөр нөлөөлж байгаа тухай хэвлэлүүд мэдээлж байна. Рублийн ханшны уналт аяллын зардлыг 20 орчим хувиар нэмэгдүүлж, эдийн засаг хямарч мэднэ гэсэн болгоомжлол гадаадад аялах оросуудын тоог бууруулж байгаа бололтой. Олон улсын жуулчдын тоо 2014 онд 1,138 тэрбумд хүрч түүхэн дээд амжилт тогтоосон боловч энэ өсөлтийг бий болгогч БРИКС түүний дотор ОХУ-ын жуулчид буурна гэдэг нь мэдээж хэрэг аялал жуулчлалын салбарын хувьд сайн мэдээ биш юм.

Аяллын зардал хумигдах үед хил залгаа, хөрш зэргэлдээ орон руу хямд зардлаар аялах явдал нэмэгдэх хандлага байдаг. Саяхан манай хоёр орны иргэд харилцан визгүй зорчдог болсон болохоор дэлхийн улс орнуудын дундаас хамгийн олон хоног цалинтай амардаг, нийтээр тэмдэглэх баяр ёслолтой орны жуулчдыг татах боломж маань ерөнхийдөө нэмэгдсэн. Гэвч энэ нь нэг их том давуу тал биш юм. Учир нь 93 улс оронд визгүй эсвэл хил дээр виз аван зорчдог хөршүүд маань энэ үзүүлэлтээрээ дэлхийн улс орнуудын 41-рт жагсаж байгаа. Нэг үгээр хэлбэл зорих газрын хангалттай сонголттой гэсэн үг. Орос жуулчдыг татахаар улс

орнууд шаргуу ажиллаж байна. Цөөн жишээ татвал Германыг зорих ОХУ-ын жуулчдын тоо сүүлийн гурван жилийн дотор 1,2 саяас 2,3 сая болж өссөн. Үүний шалтгаан нь визийн нөхцлийг хөнгөвчилсөнтэй холбоотой. Хэдийгээр Шенгений гэрээгээр ОХУ-ын жуулчид виз авах боловч виз хүсэгч нь заавал ярилцлаганд ордог, зөвхөн өөрийн биеэр визийн материалаа өгч, авдаг байсныг болиулснаар дээрх үр дүн гарсан байна. 2012 оноос БНХАУ “Хятад-Оросын аялал жуулчлалын жил” кампанит ажлыг эхлүүлсэн нь амжилттай үргэлжилж байна. БНХАУ-ын ОХУ-тай хил залгаа Манжуур зэрэг хотод хилийн боомтоо 24 цагийн турш ажиллуулж хил дээр ОХУ-ын иргэдэд виз олгож байгаа. 2009 оноос эхлэн ОХУ-ын иргэд, Хонконгийн Засаг захиргааны онцгой бүсийн байнгын оршин суугчид 14 хоногийн дотор харилцан визгүй зорчдог болсон. Үүний дүнд жуулчдын тоо 41 хувиар нэмэгдсэн мэдээ байна. Хонконгийн Аялал жуулчлалын газраас Москва, Санкт-Петербург, Сибир, Алс Дорнод руу чиглэсэн сурталчилгааг идэвхтэй явуулж өвлийн улиралд ОХУ-аас ирэх жуулчдад анхаарал хандуулснаар амжилтад хүрээд байна.

Гадаад улсууд ОХУ-ын Москва, Санкт-Петербург болон нэг саяас дээш хүн амтай 13 хотыг зорилтот зах зээлээ болгон сонгодог бол манай улсын хувьд

хөрш зэргэлдээ бүс нутагт анхаарлаа хандуулах нь илүү үр дүнтэй юм.

Тэдний аяллын хэв маяг, үйлчилгээний сонголт, зан төлөвийн онцлогийг ойлгож мэдэх, түүнд бэлдэх нь тус зах зээл дээр амжилттай ажиллах түлхүүр болно.

Саяхныг хүртэл үргэлжилсэн эдийн засгийн тогтвортой байдлаас үүдэн ОХУ-ын иргэдийн гадаад аялалдаа зарцуулах хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөөр байсан бөгөөд 2006 онд 7,7 сая байсан орос жуулчдын тоо 2013 онд 35,7 сая хүртэл огцом нэмэгдсэн юм. “IPK International” олон улсын судалгааны байгууллагаас 2014 оны арванхоёр дугаар сард явуулсан судалгаагаар оросуудын 67 хувь нь 2015 онд гадаадад өмнөхийн адил жуулчилна гэсэн бол 23 хувь нь аяллын зардлаа бууруулна, 10 хувь нь хилийн чандаа аялахгүй гэж хариулжээ.

Ямартай ч эдийн засгийн томоохон сорилтыг давж байгаа хойд хөршийн жуулчид сүүлийн жилүүдийн хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан шигээ огцом өсөлт гаргахгүй боловч энэ онд буурахгүй, дөрвөн хувийн өсөлт үзүүлнэ гэж олон улсын шинжээчид үзэж байна.

Уг нийтлэлтэй холбоотой инфографикийг дараагийн нүүрт сонирхууллаа.



Инфографик



**44%** нь буудалд буухдаа тамхи татах ерөөг сонгодог байна.

Ундааны захиалгын **23%**, хоолны захиалгын **14%** нь орос үндэснийх байдаг байна.

Аяллын үеийн үйлчилгээний сонголтод үзвэр

**70%**



ОХУ-ын жуулчдын **79%** нь утасгүй интернетийн үнэгүй үйлчилгээнд өндөр ач холбогдол өгдөг.


Жуулчдын тавидаг орос хэлтэй холбоотой хүсэлтүүд:

- 50%** нь орос хэл дээрх телевизийн хөтөлбөр
- 39%** нь орос хэлтэй үйлчилгээний ажилтан
- 35%** нь орчуулгатай хэвлэмэл танилцуулгууд
- 34%** нь орос хэл дээрх цахим хуудас



**7%** хээр хөдөө зугаалгаар явах хамгийн бага байна. Өөрөөр хэлбэл бид Оросын жуулчдыг Өмнөговь, Хөвсгөлөөс илүү Улаанбаатарт илүү олноор харх боломжтой байна.

2014 онд ОХУ-ын цахим хуудаснуудаас хамгийн өндөр өсөлттэй хайгдаж байгаа зорих газрууд:



Эндээс Азийн, тэр дундаа халуун, дулаан бүсийн орнууд ОХУ-ын жуулчдын сонирхлыг татаж байгаа нь харагдаж байна.



Фотог Б.Бямба-Очир

Мэргэжлийн хүний үг

## Гаднын аяллын компаниудтай хамтрахад 4-5 жил шаардах нь ч бий

Б.Энх-Амгалан

*“Нью Жуулчин Турс” компанийн ерөнхий менежер Д.Наранцэцэг нь Монголдоо Англи хэлээр мэргэшиж, улмаар Америкийн “Utah Valley College”-д бизнесийн удирдлагаар суралцаж төгссөн. Салбартаа хамгийн олон буюу 8-10 мянган жуулчин жилдээ хүлээж авдаг “Нью Жуулчин Турс” компанид тэрбээр нь 10 гаруй жил ажиллаж байна. Тус компанийн тоо баримтаас харахад жуулчдын тоогоор япончууд тэргүүлдэг бол араас нь Австрали, Америк, Герман ордог байна. Тус компани өнгөрсөн 10 гаруй жилд олон улсын чанартай аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцож ирсэн бөгөөд энэ жил ч Монгол улсын түнш орноор оролцох гэж буй “ITB Berlin”-нийг зорьж байгаа юм. Тэгвэл тус арга хэмжээнд оролцохын ач холбогдол болон салбарын асуудлаар Д.Наранцэцэг менежертэй ярицсанаа хүргэж байна*

**-Танай компани өнгөрсөн 10 гаруй жил тасралтгүй “ITB Berlin” үзэсгэлэнд оролцож байна. Тэгвэл чухам ямар зорилгоор, ямар үр дүн хүлээж жил бүр оролцдог вэ. Чамгүй зардал гаргаад явсныхаа ашгийг гаргаж чадаж байна уу?**

-“ITB Berlin” үзэсгэлэнд 2003 оноос хойш тасралтгүй оролцож байна. Манай компани хоёр зорилготой оролцдог. Нэгдүгээрт, түншүүдтэйгээ уулзан өнгөрсөн оныхоо ажлыг дүгнэж, ирэх

2-3 жилдээ хэрхэн хамтарч ажиллах талаар ярьдаг. Хоёрдугаарт, шинэ түншүүдтэй болох. Тэр дундаа Европоос авах жуулчдынхаа тоог нэмэгдүүлэх зорилго өвөртөлж очдог. Гэвч зөвхөн Европ бус дэлхийн аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэн учраас бүх тивийн түншүүдтэйгээ уулзаад ирдэг. “ITB Boerse”, “World Travel Market” зэрэг олон улсын үзэсгэлэнд оролцоход нэг удаад л гэхэд 20-30 сая төгрөгийн зардал гардаг. Гэвч урт хугацааны ашиг орлого

нь энэ зардлыг хэд дахин давна. Учир нь тэр олон түнштэй уулзаж, холбоо харилцаа тогтоож, ирээдүйн хамтын ажиллагааны суурийг тавьж, эхнээс нь гэрээ хийчихсэн, мөн хийхээр төлөвлөж байна шүү дээ.

**-“ITB”-гийн өгөөжид эргэлзэх, чамлах хүн цөөнгүй бий. Тэгвэл байнга оролцож ирсэн танай компанийн хувьд 2014 онд тухайлбал ямар үр дүн хүртэв. Мөн түнш орны байр сууриар “ITB”-д оролцож байгаа энэ онд ямар үр дүн хүлээж байна вэ?**

-Манай компанийн хувьд бид өнгөрсөн жил нэлээд үр дүнтэй оролцсон гэж бодож байна. Хэдий манай компаниас хоёр хүн оролцсон ч тав хоногийн дотор 80-аад компанитай уулзаж, холбоо тогтоосон. Ер нь тус үзэсгэлэнд оролцсон даруйдаа гэрээ хийх нь ховор байдаг. Өнгөрсөн жил бид “ITB”-гийн үеэр хоёр аяллын компанитай гэрээ шууд байгуулж чадсан. Үзэсгэлэнгийн үеэр л бөөн гэрээ хийгээд ирдэг юм биш л дээ. Тухайлбал, 4-5 жил дараалан тус үзэсгэлэн дээр уулзаж, ярилцсаар одоо л гэрээнд гарын үсэг зурж буй хамтрагч ч байна. “ITB” бол харилцаа, холбоо тогтоох эхний шат. Үүнийг бодит ажил болгож, компаниудтай гэрээ байгуулахын тулд уулзаж ярилцсаныхаа дараа олон дахин санал солилцож, харилцан ойлголцох хүрээнд ихээхэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй.

2011 онд Монгол Соёлын түнш орноор оролцож байсан. Тухайн үед Монголын талаар багагүй мэдээлэл олон нийтэд хүрсэн болов уу гэж дүгнэсэн. Бид түншүүдийнхээ тоог хэд дахин нэмэгдүүлнэ гэсэн том хүлээлт өвөртлөөгүй. Харин энэ удаад өргөн цар хүрээтэй оролцож байгаагийн хувьд олон нийтэд Монголыг сайн таниулж, ойлголт өгнө гэж найдаж байна. Энэ л бидний хүлээж буй гол үр дүн.

**-Та бүхэн салбарын яам задарч, Байгаль орчин, ногоон хөгжилтэй эргээд нэгдсэнийг хэрхэн хүлээж авч байна вэ?**

-Аль яаманд нэгтгэх нь сонин биш. Харин бодлого л зөв байх нь чухал. Стратеги төлөвлөгөө гаргаад бид аль зах зээлийг илүү зорилтот зах зээл болгож, Монгол дэлхийд юугаараа, яаж танигдах гээд байгааг зөв тодорхойлж, зорилгоо тодорхой болгочихсон л бол хариуцсан

яам биеэ даасан байх, харьяа байх эсэх тийм ч чухал биш.

Аялал жуулчлал гаднаас валют оруулж ирдэг салбар. Мөн олон ажлын байрыг тал бүрт бий болгодог. Тиймээс компаниудын хувьд лиценз, тусгай зөвшөөрлийн олголтыг цэгцэлж, хууль, журмаа чангатгах шаардлага өндөртэй болгох хэрэгтэй. Үгүй аваас хувь хүмүүс хэдэн жуулчин оруулж ирээд үнэ унагаах, үйлчилгээний чанарыг бууруулж байгаа нь татвараа төлөөд явж буй биднийг чирээд байгаа үзэгдэл бий.

**-Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх салбарын яамны бодлогыг одоогийн яам залгамжилж авч явна гэж буй. Танайх тусгай сонирхлын аяллууд хийдэг компанийн хувьд бодлого чиглэлийн хувьд дутагдал нь юу байна гэж бодож байна вэ?**

-Манайд тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж өндөр. Тухайлбал, япончуудын хувьд тусгай сонирхлоороо түлхүү хуваагдан жуулчилдаг. Цэцэг, эрвээхэй зэрэг байгалийн мөн морин аялал зэрэг тусгай сонирхлын жуулчлалаар ирдэг онцлогтой байх жишээтэй. Бид үүнийг дэмжиж "ITB"-д тусгай сонирхлын аяллуудын хөтөлбөрүүдийг танилцуулах гэж байна. Орон нутгийг бүсчлэн хөгжүүлэх нь зөв. Гэхдээ зөв зохицуулалт хэрэгтэй. Орон нутаг шийдэх ёстой гээд хаячихаж болохгүй. Орон нутгийн эрх мэдэл, үүрэг хариуцлага юу вэ гэдгийг сайн тодорхойлж өгөхгүй бол сүүлдээ салбарын яаманд нэгтгэгддэггүй тарж бутарсан замбараагүй болох вий гэх

зовнил бий.

**-Хамгийн үнэтэй аялал ангын аялал байдаг. Энэхүү тусгай сонирхлын аяллыг зохион байгуулах боломжийн тухайд?**

-Ангын аялал, тэр дундаа "Угалзны аялал" хамгийн үнэтэй нь. Зөвшөөрлийн тоог багасгасан учир ан хийх аялал цөөрсөн. Сонирхсон хүмүүс нэлээд байна. Гэвч лицензийн асуудлаас үүдэн анчдын тоо харьцангуй буурсан. Европ, Америкийн чинээлэг иргэд энэ төрлийн аяллыг түлхүү сонирхож ирдэг. Анчид жуулчны улирал дууссанаас хойш буюу 10-11 сард ирдэг учир дотоодын нислэгт асуудал гардаг. Анчдын хувьд энэ тэнд аялж ан хийгээд сурчихсан байдаг учир байрлах газар, хоол унд, нөхцөл голох нь бага. Харин логистикийн асуудлыг сайн зохицуулах хэрэгтэй. Тухайлбал, сайн унаа, орон нутгийн туршлагатай хөтөч зэргийг зохицуулчихсан байхад өөр асуудал бол байдаггүй.

**-Монголын аялал жуулчлалын салбар дэлхийн зах зээлд үнийн өрсөлдөх чадвар нь нэлээд сул. Тэгвэл энэ танай компанид хэрхэн нөлөөлдөг вэ?**

-Монгол руу ирэх аяллууд үнэтэй болчихоод байдаг нь үнэн. Хоол унд, тээвэр, үйлчилгээ гэх зэрэг зардал их өндөр болчихсон. Олон улсын нислэг хамгийн үнэтэй тусдаг. Жишээ нь, Бээжинд 6-7 ам.долларт боломжийн хооллож байхад Монголд 17-18 ам.доллараас нааш аятайхан хооллохооргүй болчихсон. Хонконг, Сингапурт очиж манай улсад аялаач гэж рекламдаад, өвөл үнээ хямдруулах гээд ч манай аялал зарагдах нь ховор.

Аяллын багц бусад орны ижил төрлийн бүтээгдэхүүнүүдээс илүү үнэтэйдээд байна. Хэдэн хонконг түнштэйгээ өвлийн "Ski package" / Цанын багц /гээд жил бүр үлгэр домог шиг ярьдаг. Гэвч тэд 500-600 ам.долларт бүх зардлыг нь багтаан Япон, Солонгост өвлийн аялал хийчихэж байгаа учир манайхыг тоохгүй байна. Ирж, очих онгоцны тасалбар нь л дангаараа 500 ам.доллараас хэтэрчихэж байгаа учир үнийн хувьд өрсөлдөх чадваргүй байгаад байна. Зуны улирал болохоор Монголын бүх бүтээгдэхүүн үйлчилгээтэй ижил төстэй үйлчилгээ Өвөрмонголд хоёр дахин хямд үнэтэй тул бид хоёрдугаарт орчихдог.

**-Олон улсын жуулчидтай харьцуулахад Өрнө, Дорнын жуулчдын хувьд ямар ялгаатай вэ?**

-Европууд олон жил аялсан туршлагатай байдаг учир мэдээлэл сайтай, сэтгэлийн бэлтгэл сайтай ирдэг бол азиуд хувьд мэдээлэл бага, хүлээлт бараг байхгүй ирдэг тул бүтээгдэхүүн үйлчилгээ сэтгэлд нь хүрэхгүй байх тохиолдол их. Наад зах нь хятад, солонгосчууд өөрсдийн үндэсний хоолоо иднэ гэдэг. Европчууд бол тухайн улсынхаа соёл заншилтай танилцах нь гол зорилго нь учир Монгол хоол түлхүү иддэг. Өрнөдийнхөн дор хаяж 2-3 долоо хоног аялдаг бол азиуд 4-5 хоног ирээд л буцчихдаг. Азийн хөгжиж буй орнуудаас ирж буй жуулчдын хувьд Монгол соёлтой танилцахын зэрэгцээ тав тухыг их анхаарч үздэг онцлогтой. ■





## Хоёр дахь гэр болсон Монголын минь дурсамжууд

Цагаан сарын тэмдэглэл

Тэрэнс Эдвардс /Сэтгүүлч/

Монголын уламжлалт баяруудын нэг Цагаан сар хайртай хүмүүстэйгээ уулзах, тэдэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөх гээд олон сайхан заншилтай. Миний хувьд Цагаан сар төрөлх гэрээ орхин цаст толгод, уул нуруудыг туулсаар нүүдэлчин соёлын эх орон болсон Монгол хэмээх орныг зорьж байсан тэр л дурсамжийг минь санагдуулдаг. Монголын нүүдэлчин заншлыг таньж мэдэхэд энэ баяр хамгийн их дэм болсон юм.

Таван жилийн өмнө Өвөрхангай аймгийн баруун хэсэгт орших Уянга



Тэрэнс Эдвардс Өвөрхангай аймгийн Уянга суманд амьдардаг монгол аав ээжийн хамт

суманд амьдарч байхдаа Цагаан сарыг үзэхийн тулд өөр тийшээ аялах шаардлага надад байсангүй. Монгол аав минь хадаг барин хэрхэн золгодог тухай заан сургахдаа “Өндөр настаны гарыг түшин золгох ёстой” хэмээн өөрийн гарыг минийх дээр тавьж үзүүлж билээ. Гэрийн эзэнтэй мэндлэхтэй малгайгаа яаж тайлахыг хүртэл надад нэг бүрчлэн заасан юм. “Амар байна уу?” гэж анх уулзсан хүн бүртэй түүний зааснаар мэндчилж байсан минь саяхан мэт. Түүний хатуу аялгыг өөрийнхөө хэмжээнд дууриах гэж хичээж байсан юм. Ийнхүү Уянга суманд тэмдэглэсэн анхы Цагаан сараа тэмдэглэхдээ гэр бүлийн бүх гишүүн нэг дор цуглан эцэг эх, ах дүүсдээ хүндэтгэл үзүүлэхээр ирснийг харан биширч байдаг байлаа. Цагаан сарын баярын үеэр гэр бүлд шинээр нэмэгдсэн болон хүүхэд, багачууд хэрхэн том болсныг харах боломж олгодог билээ. Гурван өдөр үргэлжилэх эл баяраар ахмадуудынхаа мэндийг эхлэн асууж, хүүхэд багачуудтайгаа удаалан мэндлэх ёстой байв. Түүнчлэн удаан уулзаагүй хамаатан, садантайгаа уулзахдаа эсвэл тэднийг үдэн гаргахдаа үнэрлэн үнсдэг заншил нь тухайн хүний үнэрийг өөрт хадгалан дахин уулзах хүртэлээ санан дурсана хэмээн үздэгтэй холбоотой аж. Шинжлэх ухаанд үнэр хүний оюун ухаанд хамгийн удаан хадгалагдан үлддэг гэдэг. Дээрх заншил үүнийг гэрчлэх хамгийн

тод жишээ болой.

Гал тойрон сууж өвлийг өнтэй давж ирж яваа цагтай хэрхэн золгосноо, мөн мал сүрэг, сонин хачинаа нэгэнтэйгээ хуваалцан ярилцана. Энэ зуур уламжлалт хоол буузаа гал дээр жигнэж, идээний дээд хэмээн архи задлан ирсэн гийчдээ дайлдаг уламжлалтай. Идээ, ундааг баруун гараараа эсвэл хоёр гараа тосон авах нь хүндлэл үзүүлж буйн илрэл юм. Энэхүү уламжлал намайг үлдээж тойрсонгүй.

Цаг цагаар нэг цадна, Цагаан сараар нэг цадна гэдэг үг оргүйгээс үүдээгүй. Энэхүү баряраар элбэг хангалуун байж, идээ ундаагаар дүүрэн байх нь ирэх жилийн өнгийг тодотгоно гэж ярьдаг. Энэ бүхэн тухайн жилдээ төдий чинээ аз хиймортой явахыг билэгддэг болохыг би тэр үед л ойлгож мэдсэн юм. Мөн ирсэн зочдынхоо гарыг цайлгах үүднээс багахан хэмжээний бэлэг өгч аян замд нь сайн, сайхныг хүсэн ерөөдөг гайхалтай сайхан ёс заншилтай ард түмэн болохыг харж суусан билээ.

Гурав дахь Цагаан сартайгаа золгож буй миний хувьд модон хонь жилдээ харж суух гаднын хүн бус айлчлан очих хүндтэй зочин болж Уянга суманд амьдарч буй монгол гэр бүлтгэйгээ золгосон.

Ийм сайхан дурсамжуудтай учруулсан энэ орныг өөрийн гэж яахан нэрлэхүй байж чадах билээ. ■

# Адал явдлын зууч “Adventure Life”-ийн түүхээс



## Бизнесийн түүх

Орчуулсан Б.Наранцогт

Брайн Морган их сургуульд байхын л Эквадор улсыг зорихсон гэж боддог байв. Учир нь түүний нэгэн танил тус улсын үзэсгэлэнт байгалийн тухай Брайны нүдэнд харагдтал ярьдаг байсан аж. Брайн ч өөрөө Испани хэл сурах сонирхолтой байсан тул 1998 онд Эквадорыг зорьсон юм. Галт уулын нөмөрт орших хот, ой дундуур урсах голоор завь “хөлөглөн” аялахын зэрэгцээ шувуудын цангинах жиргээ түүнд их таалагдаж гэнэ. Эквадор улсын гайхамшигт хөтлөгдсөн Брайн тус улсад зөвлөх мэргэжилтнээр ажиллахаар сэтгэл шулуудаад байсан ч төрөлх хотдоо буцах шаардлагатай болсон юм. Иймд тэрбээр аялах маршрутаа Болив, Перу улс руу хийсэн үүргэвтэй аялалаараа дуусгасан аж. Гэвч түүний сэтгэл зүрх Өмнөдийн улсад үлдсэн байлаа.

“Эквадор улс руу групп аялал зохион байгуулж, хамгийн сонирхолтой гэсэн газраар явах санаа надад төрсөн юм” хэмээн Брайн хожим өгүүлжээ. Ийнхүү тэрбээр санаагаа ажил хэрэг болгон “Adventure Life” хэмээх компаниа байгуулжээ. Аялагчдаа уламжлалт үзвэрүүдээс өөр, тухайн улсын үзэсгэлэнд байгаль, өв соёлтой танилцуудагаараа “Adventure Life” бусдаас ялгарах аж. Түүнчлэн аялалын зарим өдөр аялагчид тансаг буудалд тухлан саатах завшаан тохиох бол зарим өдөр бие засах өрөөгүй оромж гэж болохуйц газар ч хоноглох жишээтэй.

Гэвч Брайн Морганд бизнесээ

өргөжүүлэх санхүүгийн боломж тун бага байсан тул тэрбээр программистаар ажиллах болж, гарааны бизнесээ зав зайгаараа үргэлжлүүлж байлаа. Ингэхдээ эхний ээлжинд нэг удаагийн аялал санал болгосон 200 ширхэг тараах хуудас хэвлэн их сургуулиудын ойролцоох кафе, спорт барааны дэлгүүрүүдэд тараажээ. Харамсалтай нь, аялал сонирхож нэг ч хүн утас цохисонгүй. Аяллын агентлагууд ч түүний санааг үл ойшоов. “Сонголт арвинтай аяллыг хүмүүс түлхүү сонирхдог юм байна” гэж үзээд Брайн гурван төрлийн маршруттай, хугацааны хувьд зургаан сонголттой аяллын брошур хэвлэн тараахын зэрэгцээ холбогдох мэдээлэл бүхий вебсайт ажиллуулсан нь түүнд эхний 100 аялагчийн захиалгаа баталгаажуулах боломжийг олгосон байдаг. Түүнчлэн Брайны санал болгож байсан аяллыг залуус түлхүү сонирхох болно гэж үзсэн тул тэрбээр тээвэр, тухлах байр зэргийг хамгийн энгийнээр төлөвлөсөн байлаа. Харин түүнд хандах үйлчлүүлэгчдийн дийлэнх нь 65 хүртэлх насны хүмүүс байсан аж.

Үнийн хувьд европчуудын аялдаг ханшид суурилсан тооцоолол гаргасан боловч түүний дийлэнх үйлчлүүлэгчид америкчууд байлаа. Америкчууд Европ тивийнхнийг бодвол амралт багатай тул богино аялал сонирхдог болохыг тэрбээр мэдэж авсан юм. Брайн “Перу улс руу хийсэн анхны групп аялал алданги болж өндөрлөсөн. Бидний буухаар төлөвлөсөн байсан зочид буудал маань байрлахын аргагүй байсан. Тийм учраас аялагч

бүрийн өрөөний төсөвт 100 ам.доллар нэмж төлөөд илүү тохилог буудалд байрлаж билээ” хэмээн дурсан ярьжээ. Энэхүү анхны сургамжаас хойш тэрбээр буудаллах газартаа илүү анхаарч, аялагчдаа автобусаар бус машинаар тээвэрлэх болжээ. Иймд аяллын зардлаа 25-30 хувиар нэмэх шаардлагатай болсон байна.

Түүний бизнест түлхэц болсон бас нэгэн хүчин зүйл нь нутгийн уугуул хөтөч нар тухайн газрын ургамал, амьтан, өв соёлыг тайлбарлах чадвар хэнээс ч илүү байгааг анзаарсан явдал байжээ. Хэдийгээр америк хөтөч нараас хоёр дахин их цалин шаардаж байсан ч орон тооны гэхээсээ илүү цагаар цалинжих хүсэлтэй байсан нь Брайнд давуу тал болж байлаа. Ийнхүү орон нутгийн чадварлаг хөтөч нараар “Adventure Life” зэвсэглэж эхэлсэн байна.

“Үйлчлүүлэгч бол хаан” гэх бичигдээгүй хуулийн дагуу Брайн аялагчдаа тав тухтай байлгах үүднээс тэдэнд үзүүлэх үйлчилгээ бүрийг эхлээд өөр дээрээ туршдаг байв. Тэрбээр “Зочид буудлууд судалж байхдаа орны бүтээлэг, хөнжил, гудсыг нь хүртэл сөхөж үзэхээс эхлээд угаалгын өрөөнд мөөгөнцөр тогтсон эсэхийг хүртэл шалгадаг байлаа. Коста Рикад байхад хэн нэгэн надад аялагчдаа хүрхрээ даган олсоор буулгах тухай санаа өгсөн юм. Түүнийг туршиж үзээд бүтэхгүй гэдгийг нь шууд хэлсэн” хэмээн бизнесээ эхлүүлж байсан эхний жилүүдээ дурссан юм. ■



Миний зочин

## Д.Сумъяабазар: Өөрөө өөртэйгөө, бодож буй зүйлтэйгээ зөрчилдөх асуудлууд байдаг

Д. Бэхбаяр

**“Миний зочин” УИХ-ын гишүүн Д.Сумъяабазар. Монголчуудын уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан түүнийг урилаа. Тэрбээр олон жил Цагаан сарын баярт зориулсан барилдаанд зодоглож, олон түмнийг баярлуулж явсан юм. Харин өнөөдөр зочдын суудлаас бөхийн барилдааныг үзэж сонирхдог төрийн түшээ болсон билээ.**

**-Таны хувьд Цагаан сар нь сайхан дурсамжууд сэргээсэн баяр байдаг байх?**

-Монгол түмний эртнээс тэмдэглэж ирсэн уламжлалт баяр, хатуу сараа угтаж зөөлрүүлдэг домтой, цагаан идээ, цагаан сайхан сэтгэлээр угтдаг, өвөг дээдэсдээ өргөл өргөж, хүндлэл

үзүүлдэг, хүндэтгэлийн дээд хэлбэрийг агуулсан баяр даа.

Сар шинийн өглөө үр хүүхдүүдтэйгээ золгож, гэргийнхээ цайг ууж, бурхан шүтээндээ хүндлэл үзүүлнэ. Аав, ээж рүүгээ очиж золгоно. Дараа нь төрийн золголт, Сонгинохайрхан дүүргийнхээ ахмад буурлууддаа хүндлэл үзүүлнэ гээд жилээс жилд баяр өргөжин тэлж байна.

Би 8-16 нас хүртлээ эмэг эх дээрээ өссөн болохоор үндэсний баяраа багаасаа л төгс утгаар тэмдэглэж ирсэн. Миний хувьд Цагаан сарын баярт зориулсан үндэсний бөхийн барилдаанд хоёр түрүүлж, дөрвөн удаа үзүүлсэн амжилттай. Монгол бөх Монголын ард түмний ёс, зан заншлыг хадгалж ирсэн уламжлалтай. Цагаан сар, Улсын баяр

наадмыг бөхгүйгээр нэг төсөөлөөд үз дээ. Монголчууд маань Цагаан сарын бөхийн барилдааныг шимтэн үздэг. Тиймээс л өндөр ач холбогдол өгч, бэлтгэл сургуулилтаа сайн хийж, барилддаг байсан. Цагаан сарын барилдаанд бөхчүүд үнэнч шударгаар барилддаг. Хэн нэгэнд бууж өгөх, найр тавих ойлголт байдаггүй. Сар шинийн барилдаанд түрүүлээд, олон түмний баяр баясал, уухайн түрлэгийг сонсоод гайхалтай мэдрэмж авдаг байлаа.

**-Улстөрч, бөхчүүдэд үзүүлэх ард түмний хүндлэл мэдээж том ялгаатай. Танд мэдрэгдэж байна уу?**

-Бөхийн спортоор хичээллэхэд 20-иод жилийг зориулжээ. Ард түмэндээ

хүндлэгдсэн хайрлагдсан он жилүүд явлаа шүү дээ, миний хувьд.

Улс төрийн сонголт хийснээр эсрэг орчинд ороод ирж байгаа юм. Улс төр адармаатай зүйл л дээ. Ард иргэдийнхээ төлөөлөл болж, төрд ажиллах, тэдний санаа бодлыг төрд хүргэх үүрэг хүлээнэ. Магтуулна, шүүмжлүүлнэ, сайн, муугаараа хэлүүлнэ. Амьдралд байх л ёстой зүйлүүд. Алдаж, онож, даваа гүвээг туулж байж туршлагажина. Тиймээс би хүндээр хүлээж авдаггүй. Дээр нь улс орны эдийн засаг сайнгүй, иргэд стресстэй байна. Төрийн түшээд тэсвэртэй, хүлээцтэй байх ёстой гэж боддог. Асуудлыг зөв талаас нь харахыг хичээдэг.

**-Яагаад улс төр рүү орохыг хүсэв, яагаад Их хурлын гишүүн болохыг зорив гээд л сэтгүүлчид танаас асуудаг байх л даа. Танд сонголт байсан. Тухайлбал, монгол түмний хайртай бөхөөр үлдэх.**

-Хүмүүс янз бүрээр ойлгож ярьдаг л даа. Хүн өөрийнхөө өмнө зорилго тавьж түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө амьдарч, тэмцэж, тэрэндээ хүрсэн бол дахин шинэ зорилт тавьж энэ хүчээрээ амьдардаг. Энэ зорилго нь тэр хүнийг илэрхийлж, бусдад харагдах нэрийн хуудас нь болж явдаг гэж боддог.

Би 2008 онд МАН-д гишүүнээр элсэн ороод Сонгинохайрхан дүүрэгт иргэдтэй дөрвөн жил тулж ажилласан. Ард иргэдийн амьдрал ахуй ямар байгаа, тэд юу бодож сэтгэж, хийхийг хүсдэгийг намын анхан шатны нэгж дээр ажилласнаар илүү гүн мэдэрсэн. Хөдөө орон нутгаас ирсэн иргэд ихэнхдээ энэ дүүрэгт суурьшдаг. Нийслэлийн хамгийн том гэр хороололтой, тулгамдсан асуудал олонтой дүүрэг. Улс орны хөгжил, иргэнээс, дүүрэг, хороодоос эхэлнэ. Дүүргийн иргэдтэй тулж ажилласан дөрвөн жилд тэдний дуу хоолой болж, асуудлуудыг шийдэж, улс орны хөгжилд гар бие оролцоод явах итгэл үнэмшил төрж, шийдэлд хүрсэн. Миний л сонголт. Түүнээс хэн нэгэн даргын, эрх мэдэлтэй хүмүүсийн нөлөө байгаагүй.

**-Таны итгэл үнэмшил улс төрийн тогоон дотор орж ирээд өөрчлөгдсөн үү?**

-Өөр өөртэйгөө, бодож буй зүйлтэйгээ зөрчилдөх асуудлууд байна аа. Энэ бол үнэхээр хүнд байдаг. Шийдвэр гаргах түвшинд нэг талыг барьж

савчиж, нөгөөтэйгүүр бөөрийнхийлж, туйлшрахгүй байр сууринаас ханддаг. Бодож байснаасаа өөр зүйлүүдтэй нүүр тулж л явна. Тэр болгоныг давж гарч, бодож төлөвлөсөн, ярьснаа хэрэгжүүлэх ёстой.

**-Та УИХ-ын ангийнхнаа хэрхэн дүгнэв вэ? Та нар ч олон түмэнд бол их муу нэртэй, хэцүүл хүмүүс болж харагдаад байгаа шүү дээ?**

-Ард түмнээс мандат аваад УИХ-д ороод ирсэн гишүүдийг бүгдийг нь л чадвартай, улс эх орныхоо төлөө гэсэн сэтгэлтэй хүмүүс гэж хардаг. Иргэдийн итгэлийг олсон хүмүүс. Гагцхүү улс төрийн ойлголцлыг хийж чадахгүй байна. Улс төрийн түгжээг мулталж чадахгүй байгаа учраас өнөөгийн улс төр, эдийн засагт үүсээд буй нөхцөл байдал, хүндрэлийг давахад асуудал үүсээд байна. Нэг хэсэг нь ажил явуулах гэдэг, нөгөө нь хойш нь татаж чангаадаг. Улс төрийн энэ асуудлаас үүдэлтэйгээр улс орны хөгжил урагшлахгүй байна. Алдаатай, шүүмжлэлтэй зүйлүүд бидэнд бий. Хүлээн зөвшөөрнө. Алдааг засаад л урагшлах ёстой.

**-Та улс орны ирээдүйг хэрхэн хардаг вэ. Зарим хүмүүс ч бүрхэг боллоо гэх юм.**

-Өөдрөгөөр хардаг. Саад бэрхшээл өдөр бүхэн тохиолддог зүйл. Хамгийн гол нь саад бэрхшээлийг давж гарах төрийн оновчтой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Хавтгайрсан халамжаас илүүтэй үйлдвэрлэлээ дэмжсэн, иргэдээ орлоготой байх бодлого хэрэгжүүлэх нь зөв. Харин өмнөх удирдлагуудын алдааг хэрхэвч давтаж болохгүй. Боловсролын системийг хүний хөгжлийг дэмжсэн байдлаар шинэчлэх нь чухал байна. Тухайлбал, салбар бүрт технологи эзэмшсэн монгол инженерүүдийг олноор бэлтгэх шаардлагатай байна. Дэлхийн шилдэг технологиудыг Монголын хөрсөнд суулгаж байж улс хурдацтай хөгжинэ. Тухайн улсын нийт оюутнуудын 40-өөс дээш хувь нь инженерүүд байж улс хөгждөг гэсэн дэлхийн хөгжсөн улс орнуудын дүгнэлт байдаг.

Өнөөдрийн эдийн засгийн хүндрэл улстөрчдийн буруутай бодлого, харалган алхам ийм байдалд хүргэсэн гэдэгтэй санал нэг байна. Гэхдээ бид чиний миний буруу гээд суухгүйгээр алдаагаа засаж залруулаад хурдтай ажиллах л

чухал байна. Хийсэн алдаа завхралыг засахад хүнд байдаг. Гэхдээ л хичээх ёстой. Удаан дуншсан яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарын сонгон шалгаруулалт саяхан болж өнгөрсөн. Мөн Сангийн яам, Монгол банк, Үндэсний статистикийн газрууд хамтраад бодлого тооцоогоо нэгтгэж, түүн дээр тулгуурласан мэдээллийг Ерөнхий сайд УИХ-д хийлээ. Энэ бол нэг алхам. Олон улсын байгууллагын зөвлөмжөөс илүүтэй өөрсдөө алсыг харсан ухаалаг бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

**-Та Япон улстай ойрхон хүмүүсийн нэг. Наран улсын хөгжлөөс суралцах зүйл их байна. Таны бодол?**

-Япон улс бол эмх замбараатай, дэг жаягтай, зохион байгуулалттай, соёл хүмүүжилтэй ард түмэн. Сурах, суралцах зүйл ихтэй орон. Иргэд нь гэхэд л хувь хүний зохион байгуулалт сайтай, хариуцлагаа ухамсарласан, соёл хүмүүжилтэй. Япончуудын өдөр тутмын цагийн менежментийг манай залуус амьдрал ахуйдаа авч хэрэгжүүлээсэй гэж боддог.

Дэлхийн гурав дахь том эдийн засагтай орны яг юуг нь Монгол улсынхаа хөрсөн дээр буулгах вэ гэдгийг сайн судлах ёстой. Түүнээс Японы нийгэм бүхэлдээ сайхан биш шүү дээ. Саар зүйл ч бий. Саараасаа сайн нь их юм даа. Төрийн бодлого нь зах зээлийн хатуу зарчмаар явдаг, дайн байлдаан, зовлон их үзсэн ард түмэн. Дөрвөн жилийн өмнө газар хөдлөлт, Цунами болоход төр нь ч, иргэд нь ч ямар гайхалтай зохион байгуулалтад орж, ажилласныг бид харсан.

Тэгэхээр манай улсад хөгжих боломж бүрэн бий. Өргөн дэлгэр нутаг дэвсгэртэй, баялагтай, хүн ам маань гурван сая боллоо. Хүнээ л хөгжүүлэх талд бодлого хэрэгжүүлж, боловсролын салбарт дорвитой хөрөнгө оруулалт хиймээр байна. Аливаа улс орны үнэ цэнэ бол хүн нь байдаг.

Японы боловсролын сургалтын систем сайн шүү дээ. Тус улсад 1000 инженер бэлтгэх ажил эхнээсээ хэрэгжээд эхэлсэн явж байна. Үнэхээрийн том хөрөнгө оруулалт. Манай их, дээд сургуулиуд шууд л онолоор бөмбөгддөг бол Японд өөр. Тухайлбал, Коосен их сургуулийн оюутанд эхлээд практик орно. Гагнуурын мэргэжлийн

ангийн оюутны гарт нь шууд гагнуур бариулдаг юм билээ. Химийн чиглэлээр сурдаг хүүхэд химийн бодисуудтай эхлээд харьцана. Манай сургуулиуд энэ туршлагыг судалж нэвтрүүлэхэд анхаарах л ёстой.

**-Манай хоёр улсын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа эхэллээ. Бид Японоос юу оруулж ирвэл хөгжилд тустай бол?**

-Өндөр технологи оруулж ирэх ёстой. Тэгэхийн тулд хүнээ бэлтгэх шаардлагатай. Байгальд ээлтэй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй технологиор дэлхийд гайхуулж яваа улс. Ялангуяа автомашин, мэдээллийн технологи, био, нано технологийн зах зээлд дэлхийд тэргүүлж байна. Хүрээлэн буй орчинд хөнөөл багатай, бензин бага иддэг, сэргээгдэх эрчим хүчээр явдаг Тоёотогийн автомашинууд дэлхийн улс орнуудын зах зээлийг эзэлж байна. Технологийн хувьсгалыг япончууд хийж байна.

**-Тэгвэл Монголоос Япон руу юу экспортолбол үр дүнд хүрэх вэ?**

-Олон бүтээгдэхүүн байж болно. Жишээ нь: ноос, ноолуур, мах махан, сүү сүүн бүтээгдэхүүнүүд гэх мэтчилэн. Гагцхүү эдгээр бүтээгдэхүүн Японы зах зээлийн стандартад нийцсэн, өрсөлдөх чадвартай, эрүүл ахуйн шаардлага хангасан байх ёстой. Бид ч чанарын өндөр түвшинд ажил хийж сурна. Тиймийн тулд төр бодлогоор хүний нөөцөө бэлтгэж, нөхцөл боломжоор хангах учиртай. Аль аль талаас нэлээд хүч, хугацаа шаардах ажил. Ямар бүтээгдэхүүнийг экспортлох талаар судалгаа шинжилгээ сайтар хийж, бодитой бодлого боловсруулж, тэр зах зээл рүү гарах нь чухал юм аа.

Манай хоёр орон өнгөрсөн жилүүдэд соёл, спорт, нийгмийн чиглэлээр найрсаг хамтын ажиллагаатай явж ирсэн. Одоо нэг шат ахиж, эдийн засгийн түншлэлийн хэмжээнд харилцаа дээшилнэ гэдэг нь манай улсын хувьд том боломж.

Япончуудын олон мянган жилийн түүх соёлыг хадгалсан спорт нь Сумо бөх. Эзэн хааныхаа ивээл дор байдаг мэргэжлийн спорт. Тус орны ийм нандин уламжлал дээр Монголын хүчтэй, бяртай ухаантай залуус сумо бөхийн дэвжээг эзэгнэж байна. Олон монгол залуус

үндэсний бөхөөр нь дамжуулан Японы ард түмний оюун бодолд Монгол улсыг шингээж өгсөнд талархдаг. Энэ оюуны санааны дархлаа дээр эдийн засгийн хамтын хамтын ажиллагааг эрчтэй хөгжүүлбэл ихээхэн ач холбогдолтой зүйл болно.

**-Япон сонгодог Парламентийн засаглалтай орон. Ерөнхий сайд Шинэо Абэ Парламентаа тараагаад эрх мэдлийг дахин гартаа авч, өөрийн бодлогоо тууштай хэрэгжүүлж байна. Харин манай Ерөнхий сайдад ийм эрх мэдэл байна уу. Парламентаас хараат болсон хүн харагдах юм.**

-Би сонгодог Парламентын хэлбэр рүү явах нь зөв гэж хардаг. УИХ-ын сонгуульд ялсан намын дарга нь Ерөнхий сайд болж, засгаа бүрдүүлээд, хөтөлбөрөө хэрэгжүүлээд явдаг. Бодлого төлөвлөгөөг нь дэмжихгүй байвал Парламентаа ч тараах эрхтэй байх хувилбар илүү зөв. Олон улс орон ийм зарчмаар явж байна.

Өнөөдөр манай Ерөнхий сайд шийдвэр гаргадаг ч юм шиг, гаргадаггүй ч юм шиг, хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага гэдэг шиг л байгаа. Алив том асуудлууд гацаад байгаа шалтгааныг би энд байна гэж хардаг. Улс төрийн ойлголцол байхгүйгээс Их хурал дээр асуудлууд унаж гацаанд орчихдог. Засгийн газрын хэрэгжүүлэх бодлогууд урагшаа явахгүй байна. Парламентад олон жил суусан гишүүд шүүмжлэх л байх л даа. Их хуралд дөнгөж орж ирчихээд юу яриад байгаа юм гэж. Шинэ орж ирсэн хүний нүдээр харахад гацааны шалтгаан энд л байгаа юм.

**-Улс төрийн энэ гацаа хэдий хүртэл үргэлжлэх бол. Хэзээ ойлголцолд хүрэх юм бэ? Одоо бид юу хийвэл зохилтой вэ?**

-Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай хуулиндаа өөрчлөлт оруулахаас гадна нэгдсэн нэг хөгжлийн бодлоготой болсон цагт улс төрийн гацаа арилж ойлголцолд хүрэх байх.

Өнөөдөр мега төслүүдийг урагшлуулмаар байна. Оюутолгой, Тавантолгойн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь бас зөв. Хамгийн гол нь улс төрийн ойлголцол, шийдвэр нэг шугам дээр очих ёстой. Тэгж байж энэ төслүүд саадгүй хэрэгжинэ. Дараа

нь уул уурхайгаас олсон мөнгөө хэрхэн зарцуулах вэ гэдэгт оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал байна. Татвар төлөгчдийн мөнгийг иргэдэд халамж хэлбэрээр олгох, баялгийн санд хуримтлагдах хөрөнгийн эх үүсвэрийг тараагаад өгөх нь оновчтой бодлого мөн үү. Олон хүмүүсийн хөдөлмөр, хөлс хүч, үнэ цэнэ шингэсэн мөнгө гэдгийг маш сайн бодох ёстой.

**-Та монгол хүний үнэ цэнийн тухай ярьж байна. Тэр дундаа монгол эр хүний үнэ цэнэ унаад байна. Тэд архинд орж, гэр бүлээ тэжээх чадваргүй сул хүмүүс болж байгаад та ямар бодолтой явдаг вэ?**

-Монгол эр хүн бол хамгийн түрүүнд өөрийгөө хайрлаж чаддаг байх ёстой. Өөрийгөө хайрлаж буй хүн өрөөл бусдыг хайрлана. Өөрийгөө хайрлахгүй хүн өрөөлийг ч хайрлахгүй, хайрлаж ч чадахгүй. Өөрийгөө хайрладаг хүн өрх гэрээ, улс орноо хайрлана. Өөрийгөө хайрлана гэхээр биеэ оторлоод хүндлүүлээд, халамжлуулаад суухын нэр биш шүү. Өөрийгөө эрүүл байлгах, боловсруулах, зөв амьдралын хэвшилтэй болгохоос эхэлнэ. Монгол эр хүн айл гэрийн ноён нуруу, сайн аав байх нь хамгаас чухал. Монгол эр хүн чадалтай чадвартай, соёлтой, боловсролтой, өрх гэрээ сайн аваад явдаг, улс орондоо хүчтэй дуу хоолой болж тулах багана нь байх нь зүй ёсны юм. Ийм байхын тулд гэр бүлийн хүмүүжил ихэд нөлөөлдөг. Гэр бүлийн хүмүүжлийн тухай би байнга ярьдаг нь нийгэмд ямар хүн болоход ихэд нөлөөлдөг учраас тэр. Тиймээс эцэг эхчүүд хүүхдээ багаас нь зөв хүмүүжилтэй зөв хүн болгоход анхаарах ёстой.

Монгол хүний, эр хүний үнэ цэнийг өсгөх талд бодож буй зүйлүүд бий. Монгол эр хүний үнэлэмжид төр анхаарах цаг болсон. Ялангуяа 1950,60,70-аад оны хуучин ЗХУ-д сургууль төгссөн олон сайхан хүмүүс зах зээлийн давалгаанд өртөж, түүнээсээ гарч чадахгүй явсаар нийгмийн нэгэн эмзэг хүмүүс болон хувирсан. Жишээ нь би СХД-ийн 7-р хорооны иргэдтэй уулзаж айлуудаар ороод явах үедээ архинаас болж амьдралаа алдсан нэлээд хэсэг залуустай уулзсан юм.Тэдний дунд эхнэр хүүхдээсээ салсан нэг залуу хуучны компьютер дээр Эртний хүннү



нарын тухай нийтлэлийг орос хэлнээс орчуулаад сууж байх жишээтэй.

Тэгэхээр монгол эр хүний, монгол айл өрхийн ноён нурууг дээш нь татахгүйгээр Монгол улс хөгжихөд хүндрэлтэй. Бас нэг асуудал байна. Гэрийн эзэн, эзэгтэй хоёрын үүрэг оролцоо ялгавартай болоод ирэхээр зөрчил үүсэж, улмаар салж сарних, хүүхэд өнчрөхөд хүрч буй жишээ олон. Айл гэрийн эзний үүрэг, мэдлэг боловсрол, чадвар эхнэрээсээ сул болоод ирэхэд дээрх асуудлууд үүсч байна. Монгол гэр бүлийн хоорондын халуун бүлээн уур амьсгал алга болж байна. Төрөөс энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, судалгааны газруудтай хамтарч ажиллах замаар энэ асуудлыг монгол төрийн бодлогын түвшинд авч үзэж ажиллах цаг болсон гэж бодож байна.

**-Танайх боломны танил гэр бүл. Олонд танил байхын зовлон, жаргал юу байдаг вэ?**

-Ард түмнийхээ дунд хайрлагдан хүндлэгдэх шиг сайхан зүйл байхгүй л дээ. Ард иргэдийнхээ хайр хүндлэлийг авах хүртэл бас нэлээд хөдөлмөрлөж зүтгэнэ шүү дээ. Биеэ зөв авч явах, ярих, хэлэхдээ анхаарах хэрэгтэй болдог. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлах шаардлагатай. Ирээдүй хойч үедээ зөв үлгэр дуурайл үзүүлэхэд олны хайр хүндлэлийг авсан хүмүүс анхаардаг болов уу. Түүний төлөө бид хичээдэг.

Заримдаа хэцүү ч юм шиг санагдах үе бий. Хүн бүхэн танина, хүмүүсийн анхаарлын төвд орно. Хэлэх ярихыг

сонсоно. Шар хэвлэлээр элдвээр хэлүүлээд явахад халширмаар үе байдаг. Сүүлдээ ч дөжирнө. Дэлхийд байдаг л жишиг. Би эхнэртэйгээ нэг удаа бид хоёрын талаарх янз бүрийн мэдээллийг хүмүүс уншаад юу гэж боддог болоо гэж хоорондоо ярилцаж байсан. Гэхдээ хүмүүс буруу зөрүү мэдээлэл гэхгүйгээр шууд тусгаж авдаг юм билээ. Бид хоёр ханилаад 20-иод жил болж байна. Дам үгээр, олны танил гэдгээр нь гүтгэж бичсэн олон мэдээлэл гардаг байсан. Тэр бүхэнтэй зууралдахыг хүсдэггүй. Хийх ажил их, урагшлах хэрэгтэй шүү дээ.

**-Таны ширээний ном?**

-Түүхийн номнууд унших дуртай. Багадаа түүхийн ном их уншдаг байлаа. Сүүлийн үед эрх зүй, эдийн засаг, санхүү, менежментийн номууд их уншиж байгаа. Мөн танай сэтгүүлийн байнгын уншигч. Ширээн дээр менежмент, санхүүгийн номнууд л байнга байдаг. Сүүлийн өдрүүдэд Д.Лүндээжанцан гишүүний саяхан Төрийн соёрхол хүртсэн бүтээл "Төрийн эрх мэдлийн хуваарилалт" номыг уншиж дуусаад дахин эргүүлж харж байна даа.

**-Та УИХ дээр банк санхүү, мөнгөний бодлого, хөрөнгийн зах зээлийн талаар нэлээд жинтэй үг хэлдэг. Энэ чиглэлээр нэлээд туршлага хуримтлуулсан гэж харагддаг.**

-Би бизнесийн удирдлагын чиглэлээр суралцсан. 2005 оноос банкны салбарт найман жил ажилласан. Голдмэн сагс,

Дойче банк, Юнайтед банк оф Свисс/UBS/зэрэг дэлхийн санхүүгийн томоохон төлөөлөгчидтэй хэлэлцээрийн ширээний ард суухад энэ чиглэлийн хангалттай мэдлэгтэй байхыг шаардана. Иймээс ч миний хувьд санхүү, мөнгөний бодлого, санхүүгийн зах зээлийн талаар их уншиж, судалсан. УИХ-д эдийн засгийн зорилт, санхүү, хөрөнгийн зах зээл, банкны бодлогын чиглэлд дуугарч, санаа бодлоо хэлдэг. Энэ чиглэлээр ажлын хэсгүүдэд ч намайг их оруулдаг.

Монгол улс одоо банкны зах зээлд тулгуурласан системийг задлах хэрэгтэй байна. Хөгжлийн нэг гарц энэ юм. Хөрөнгийн биржийг хөгжүүлж, санхүү, хөрөнгийн зах зээлийг тодорхой түвшинд богино хугацаанд гаргаж ирэх шаардлагатай. 2012 оноос манай хөрөнгийн зах зээл унасан. Хаагдмал түгжигдмэл байдалтай явж ирлээ. Хөрөнгийн бирж, СЗХ, Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн төвийг шинэчлэх, ажлыг нь хурдасгамаар байна. Эдгээр байгууллага өөрсдөөсөө эхэлж шинэчлэгдэх ёстой. Сангийн яам, Монгол банкны бодлогуудтай уялдаа холбоотой ажиллах шаардлагатай. Санхүүгийн зохицуулах хороо нь үйл ажиллагаа явуулах эрх олгочихоод араас нь өөрөө өөрийгөө шалгадаг биш санхүүгийн үйлчилгээ, хяналтын хороо нь тус тусдаа байж ажил явна.

Шинэчлэл нэрээр эрс шинэчлэгдсэн зүйлгүй, өмнөхөө улам нураагаад байна. Энд төрийн алсыг харсан оновчтой бодлого хэрэгжих шаардлагатай гэж хардаг.

**-Сар шинийн баярын үеэр ярилцаж байгаа учраас та манай уншигчдад хандан мэндчилгээ дэвшүүлнэ үү?**

-“Mongolian Economy” сэтгүүлийн байнгын уншигчийн хувьд Монгол улсын эдийн засаг, бизнесийн талаар бодитой, анализ судалгаатай, тэнцвэртэй мэдээлэл өгдөгт нь танай хамт олонд талархаж явдгаа илэрхийлье.

Нийт уншигчиддаа хандаж эдийн засгийн бэрхшээл түр зуурынх. Алдаа оноо дээрээ тулгуурлан хүндрэлийг даван туулахын төлөө төр нь ч зүтгэж, түмэн олон нь ч дэм өгч байж хүндрэлээс гарна гэдгийг хэлмээр байна.

Та бүхэндээ шинэхэн гарсан модон хонин жилийн мэндийг хүргэж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. ■



## Польш улсаас Польш үндэстний зоог санал болгож байна. Сайхан хооллоорой!

Польш улс Европын холбооны 28 орноос Монгол Улстай худалдаа хийж буй орнуудын эхний гуравт багтдаг. Өнгөрсөн оны эхний гурван улирлаас харвал тус улсаас Монголыг чиглэх экспорт 27 сая еврогоор хэмжигдэж байв. Үүний 90 хувийг хүнс, гоо сайхан, цахилгаан барааны экспорт эзэлдэг байна. Ирээдүйн хөгжил хэрхэх бол?

Польш улс Европын холбоонд нэгдсэнээс хойш тус улсын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтээмж 2004 онд таван тэрбум еврод хүрсэн бол үүнээс хойш гурав дахин нэмэгдэж, улмаар 2012 онд 17.9 тэрбум евро болон өргөжив. Тус улсын экспортын бараа, бүтээгдэхүүний 80 орчим хувь нь Европын хөгжингүй орнуудад гардаг бөгөөд хөгжиж буй орнуудад нийлүүлж буй бүтээгдэхүүний хувь, хэмжээ жил бүр өсөн нэмэгдсээр байна.

Мах, ногоо, жимс, өндөг, сүүн бүтээгдэхүүн нь Польш улсын экспортын дийлэнх хувийг эзэлдэг боловч тус улсын үндэсний хүнс, зоог экспортын боломж нээж буй маш сонирхолтой салбар юм. Польш улс Европын холбоонд нэгдсэнээс хойш тус улсын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтээмж 2004 онд таван тэрбум еврод хүрсэн бол үүнээс хойш гурав дахин нэмэгдэж, улмаар 2012 онд 17.9 тэрбум евро болон өргөжив. Тус улсын экспортын бараа, бүтээгдэхүүний 80 орчим хувь нь Европын хөгжингүй орнуудад гардаг бөгөөд хөгжиж буй орнуудад нийлүүлж буй бүтээгдэхүүний хувь, хэмжээ жил бүр өсөн нэмэгдсээр байна.

Мах, ногоо, жимс, өндөг, сүүн бүтээгдэхүүн нь Польш улсын экспортын дийлэнх хувийг эзэлдэг боловч тус улсын үндэсний хүнс, зоог экспортын боломж нээж буй маш сонирхолтой салбар юм. Польш улсын Хөдөө аж ахуйн яам нь үндэсний зоогийн уламжлал, чанарыг онцлох зорилгоор “Уламжлалт бүтээгдэхүүний жагсаалт”-ыг гаргасан. 2014 оны сүүл гэхэд энэхүү жагсаалтад 1341 хүнсний нэр зүйлийг багтаажээ.

Польш улсын хамгийн алдартай зоог нь пиероги. Пиероиг исгээгүй гурилаар бүрж чанах, жигнэх эсвэл сонгинотой тосонд шарах аргаар хийдэг. Пиероги дотор төмс, шинэ бяслаг, исгэлэн байцаа, мөөг, татсан мах эсвэл жимс /ялангуяа олон янзын жимсгэнэ/ оруулан хийдэг аж. Польш үндэстний бас нэгэн уламжлалт хүнс нь бигос буюу байцаанд ороож, жигнэсэн мах юм. Бигосыг хийхдээ ихэнхдээ жирийн эсвэл исгэлэн байцаа, төрөл бүрийн мах /гахай, үхэр, бугын жигнэсэн, утсан мах/, хиам эсвэл бусад ногоо, чавга, дарс, мөөг болон уламжлалт халуун ногоо зэргээр амталдаг байна.

Польшийн хүнсний бүтээгдэхүүнүүд Европын холбооны хүнсний чанарын системийг баримталдаг. Тухайлбал, Гарал үүслийн тодорхойлолт /PDO/, Газарзүйн бүсийн тодорхойлолт /PGI/ болон Уламжлалт аргаар бэлтгэсний баталгаа /TSG/ зэргийг хангах үүрэгтэй байдаг аж. Эдгээр баталгааг хангасан Польш үндэстний 36 хоол байдаг. Үүнд, уламжлалт бяслаг /bryndza podhalanska, oscypek, serg korycinskie, redykolka/, Попкарпацие болон Сэний бүсийн зөгийн бал, Затор бүсийн мөрөг загас, Кашубын хүлэмжийн гүзээлзгэнэ болон Подхалийн бүсийн интоор, шош, алим, хурганы мах, төрөл бүрийн талх нарийн боов /rogal swietomacinski, koacz slaski/ зэрэг ордог.



Хэрэв та Польшийн хүнсний салбарын компаниудтай холбогдож, тэдний экспортлох бүтээгдэхүүний талаар сонирхож байгаа бол доорх хаягаар холбогдоно

Худалдаа, хөрөнгө оруулалтын салбар  
1, Ритан Лу, Жиангуомэнвай  
100600, Бээжин, БНХАУ

утас: +86-10-65321888 факс: +86-10-65324958  
и-мэйл: Beijing@mg.gov.pl  
www.beijing.mfa.gov.pl



INNOVATIVE  
ECONOMY  
NATIONAL COHESION STRATEGY



EUROPEAN UNION  
EUROPEAN REGIONAL  
DEVELOPMENT FUND



## Бизнесмэнүүдийг өмөөрөхүй



Д. Бэхээ

Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Сэтгэлгээний хувьсгал” нийтлэл олонд хүрэв. Тэрбээр үл тэсвэрлэхдээ ард иргэд, улстөрчдөд хандаж, үзэг цаас нийлүүлэхээр шийдэж. Харин манай сэтгүүлийн хувьд “Сэтгэлгээндээ шинэчлэл хийе” буланг хоёр жилийн өмнөөс хөтлөн явуулж, олон салбарын мэргэжилтнүүд сэтгэлгээндээ шинэчлэл хийхгүйгээр Монгол хөгжихгүй гэдгийг хэлж ирсэн. Тэгвэл Ерөнхийлөгчийн бичсэн нийтлэлд ч энэ санаанууд туссан байна. “Тухайлбал “Монголчууд шулуун замаар ч явж чадахаа байсан. Ардах нь урдахиа дэгээдэж унагадаг. Бүгд орооцолдож унасан дороо хий эргэсэн хүмүүс. Одоо энэ байдлаа ухаарах цаг болсон. Ийм байдлаа өөрчлөхгүй бол бид өөдлөхгүй. Монгол хөгжихгүй”.

Өөр нэг санааг нь онцлон тэмдэглэе. “Хорлолын тухай цөөхөн ярьсан. Бүтээх гэснийг бүтээлгэхгүй хорлодог. Барих гэснийг бариулахгүй хорлодог. Гарах

ёстой шийдвэрийг гаргуулахгүй хорлодог. Хийх ёстой ажлыг хийлгэхгүй хорлодог. Нааш харсныг цааш хартал хорлодог. Монгол хүнийг мохтол хорлодог. Гаднын хүнийг гартал хорлодог. Зөв сэтгэлтнийг буруутгаж хорлодог. Буруу сэтгэлтнийг баярлуулж хорлодог. Ийм хорлолын төлөө хариуцлага хүлээх хүнгүй болгож хорлодог” гэжээ.

Бидний нийтлэлийн санаа нэг шугам дээр огтлолцож байгаа юм. Миний хувьд энэ удаа үндэсний томоохон компани, бизнесмэнүүдийг өмөөрөх гэсэн юм. Монголчуудын атаархуу зан улс орноо хөгжүүлэхгүй байгаа юм аа гэж гаднын танилын маань хэлсэн үг үнэн.

Бид үнэхээрийн л атаа жөтөөрхүү хүмүүс ажээ. Бизнесийн зарчмаараа явж, хөдөлмөр зүтгэлийнхээ үр дүнг амсаад гараад ирсэн нэгнээ шууд л намнаж өгнө. Хаанаас, юугаар баяжаад гараад ирэв, хэний мөнгөв гээд л зүрхийг нь мохоогоод буулгаад авна. Гэтэл гаднын

ард иргэд их өөр юм аа. Сэтгүүлчийн хувьд Япон, Америк, Тайвань, Өмнөд Солонгос улсуудад очиж, хөгжлийн нууцыг нь сурвалжилж явлаа. Эдгээр орны хүмүүс нь үндэснийхээ компани, бизнесмэнүүдээрээ харин ч ихэд бахархаж, хүндлэх юм билээ. Манай Тоёото, Сиймэнс, Хьюндэй гээд л. Харин монголчууд бидэнд ямар бахархал байна вэ? Чингис хаан. Бидний мөнхийн бахархал мөн. Өөр?

Улсын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, бодитой үр дүн гаргаж яваа компаниуд манайд олон бий. Хувийн хэвшлийнхний өгсөн мөнгөөр төсөв бүрддэг, хөгжилд зарцуулдаг. Үндэсний компаниудаараа бид бахархаж багдаж сурах хэрэгтэй байна. MCS, МАК, АПУ, Женко, Таванбогд, Энержи ресурс, Петровис гэх мэт. Эдгээр нь хилийн чанадад бол мэдээж жижигхэн компаниуд ч Монгол Улсад хөгжлийн ачааллыг нуруун дээрээ үүрч яваа

том аж ахуйн нэгжүүд. Эднийгээ л төр сайтар дэмжээд өгвөл улсын хөгжил улам хурдсаж, иргэдийн маань амьдрал сайжрах бус уу.

Ер нь улс орнуудын хөгжлийн загварыг харахад том компаниудаа дэмжээд явахаар тэдгээр нь жижиг, дундаа чирээд хөгжсөн туршлага бэлхнээ л байдаг. Өмнөд Солонгос улс Хьюндэй, Сиймэнс гэсэн хэдхэн том компани дэмжсэний хүчээр өнөөгийн Солонгос орныг цогцлоосон түүх бий. Тэгвэл бид үндэсний том компаниудаа үндэстэн дамнасан корпорацийн хэмжээнд хүртэл дэмжиж өгмөөр байна. Араас нь дараагийн томоохон баялаг бүтээгчдийг мөн бодлогоор гаргаж ирж, төр нь ч, иргэд нь ч дэмжвэл цөөн хүн амтай улс богино хугацаанд хөгжих боломж байгааг гадныхан харчихаад хэлээд л байгаа.

Монголчууд бидний гол дутагдалтай чанар үндэсний компаниудаараа бахархахын оронд шүүмжилж, загнаж, атаархаж суудагт байгаа юм. Муусайн баячууд, авлигачид гээд л. Төр нь ч дэмжихийн оронд шалгаж, дарамталдаг. Ийм байхад улс яаж хөгжих вэ. Тэд өдөр шөнөгүй ажиллаж хөдөлмөрлөж, олон бэрхшээлийг даван туулж байж өнөөдрийн өндөрлөгт хүрсэн. Олон мянган хүнийг ажлын байраар хангаад явж байна. Улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулаад байгаа нь нүдэн дээр ил байна. Тэд эх орноо жинхэнээсээ хайрладаг хүмүүс. Тийм учраас тэд улсынхаа хөгжилд өнгө нэмсэн барилга байшин, эмнэлэг сургууль, зам, гүүр, том бүтээн байгуулалтууд босгож байна. Тэд оюуны болоод бодитой хөрөнгө оруулалт ихээр хийдэг. Тэд олон мянган хүнийг ажлын байраар хангаж, ар гэрийг нь тэжээдэг. Тэд улстөржиж, биенээ хэмэлж, хүнд суртал гаргаагүй. Тэд бизнесээ урагшлуулахын төлөө хүнд нөхцөлд өвдөг сөхрөлгүй уйгагүй хүчин зүтгэж байна.

Тэд өвдөг сөхөрвөл, компаниудын үйл ажиллагаа нь зогсвол юу болох вэ. Олон иргэн ажилгүй болж, тэднийг дагасан олон бизнес, үйлчилгээнүүд зогсож, улмаар улсын төсөв тасрахад хүрнэ. Төсөв тасарна гэдэг чинь төрийн ажил зогсохын дохио. Тиймээс тэд зогсох эрхгүй.

Бизнесмэнүүд бол хариуцлагаа ухамсарласан хүмүүс. Тэд шинийг санаачилж, улам л урагшлан зүтгэхийг хичээдэг. Тэр хэрээр бизнес нь өргөжиж, илүү олон ажлын байр бий болж, улс хөгждөг. Энэ хөгжлийн циклийн төлөө явж буй хүмүүсийг бид харин шуналтай, баян тарганаар нь дуудаж, атаархаж, хорсдог. Тэд зүгээр сууж байгаад баян тарган болчихоогүй. Тэд уйгагүй хөдөлмөрийнхөө үрийг амсаж, сайхан хаус, машин тэрэг, дансандаа мөнгөтэй байгаа хүмүүс. Гар хөдөлбөл ам тосдоно гэсэн зүйр үг байдаг даа. Тэд чинь төрөөс баяжсан тэрбумтангууд биш ээ. Тархи толгойгоо, гар хөлөө хөдөлгөн байж олсон мөнгөөрөө амьдарч буй улс.

**“ Монголчууд бидний гол дутагдалтай чанар үндэсний компаниудаараа бахархахын оронд шүүмжилж, загнаж, атаархаж суудагт байгаа юм. Муусайн баячууд, авлигачид гээд л. Төр нь ч дэмжихийн оронд шалгаж, дарамталдаг. Ийм байхад улс яаж хөгжих вэ. Тэд өдөр шөнөгүй ажиллаж хөдөлмөрлөж, олон бэрхшээлийг даван туулж байж өнөөдрийн өндөрлөгт хүрсэн. ”**

Төрийн мөнгөөр хүүдэгнэж, баяжин, толгой дээгүүр яваа хүмүүстэй адилгүй.

Сүүлдээ манайхан хэлэх үгээ олж ядаад үндэсний томоохон баялаг бүтээгчдээ төрд, улстөрчдөд авлига өгч баяжсан гэдэг. Энэ тухайд би бас л бизнесмэнүүдээ өмөөрөх гээд байна.

Манай төр ямар билээ, улстөрчид гэж хэн билээ. Хувийн хэвшлийнхний хувьд цаг хугацаатай уралдан ажилладаг хүмүүс аль болох цаг хэмнэхийг хүснэ. Цаг хэмнэсэн байдлаар ажиллахыг хичээдэг. Манай засаг, төр хуулийн хүрээнд асуудлыг хурдан шуурхай шийдэж өгдөг бил үү. Төрийн түшээдийн хүнд суртал хир билээ. Тэдний хүндхэн ширээний шүүгээнд бичиг баримт хэд хонодог билээ. Асуудлаа хурдан шийдвэрлэж, том хөдлөхийн тулд таньдаг нөхөд, авлига, мөнгө төгрөгийг нь өгөөд ажлаа явуулахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсдэг тухай олон бизнесмэн ярьдаг.

Харин Сингапур шиг улсад хувийн хэвшлийнхний зүгээс авлига, мөнгө төгрөг, танил тал яривал өөр хэрэг л дээ.

Бизнесмэнүүдийн ёс зүйн тухай ярих нь зөв болно. Манай олонхи бизнесмэнд, компаниудад ийм байдал тулгардаг. Түүнээс улайм цайм, луйврын, буруу аргаар хөлжиж, улсдаа хөгжил бус харин ч хохирол үзүүлж яваа хүмүүсийг хэлээгүй, тийм хүмүүсийг өмөөрөөгүй.

Монгол улс үндэстэн дамнасан компанийг төрүүлэх ёстой. Тэгж байж хурдацтай хөгжинө. Үүний эхлэл нь “Энержи ресурс” гэж харж байна. Монгол нүүрсийг дэлхийн брэнд болгох зорилгоор Засгийн газраас тодорхой бодлогоор үндэсний компанийн шалгуур тавьж оруулж ирсэн гэж сэтгүүлчийн хувьд харж байна. Зөв бодлого. Дотоодынхон чадахгүй мэдэхгүй гэхийн оронд гадны томчуудтай нийлээд ажиллавал туршлага, мэдлэг хуримтлуулж, дараагийн том төсөлд араасаа монгол компаниудаа дагуулан орно шүү дээ. Тавантолгойн ордыг хэрхэн ашиглах хэлэлцээр үргэлжилсээр байна. Хажуугаар нь нөгөө атаа жөтөө, хардалтын ажлууд бас эхэлсэн. Бидний оронд өөр улсын иргэд байсан бол “Энержи ресурс”-ыг дэмжиж, амжилт хүсэх байх байсан гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Бид яагаад ийм оюуны хомсдолд орчихсон юм бэ. Яагаад бусдыг муулах, шүүмжлэхийг илүүд үзээд байна вэ. Байнгын л болохгүй бүтэхгүй байна гэж ярих. Болж бүтэж буй асуудал Монголд алга юм шиг загнаж байна. Гадаадад буй монголчууд хэвлэлээр байнгын л муу муухай мэдээ гарах юм гэж ярьж байсан. Бид саарын хажуугаар сайн зүйлээ эрүүл нүдээр харж, яагаад магтан дуулж, талархаж, өмөөрч, ярьж болохгүй гэж.


“Юмыг бүтээх биш нураах нь сайхан юм шиг. Мөнгө хүчээ үйлдвэрт, бүтээн босголтод биш нэгнээ харлуулах, гутаах төлбөрт зориулах нь хожоотой мэт харагдах боллоо. Ингэж л эх орноо “хайрлах” нь зөв мэт. Ийм байдалд олон нийт ч автаж, түүнийг сөрсөн хэсэг нь улам нүд үзүүрлэгдэх янзтай. Ямар сайндаа хамба лам Д. Чойжамц гуай “Бид бие биенээ муулах, харлуулах нь хэтэрлээ” гэж сануулжээ.

Эцэст нь хэлэхэд, Монгол Улсын тэргүүн Ц.Элбэгдоржийн нийтлэлдээ бичсэн сэтгэлгээний хувьсгалыг хийсэн цагт бид хөгжинө. Эрүүлээр сэтгэе, харья. ■


Тоон мэдээ

Монгол Улсад орж ирж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 онд огцом өсч тав орчим тэрбум ам.долларт хүрсэн. Харин өнгөрсөн онд манай улсад 542 сая ам.долларын хөрөнгө орж иржээ. Энэ нь 2008 онтой харьцуулахад өсөлтгүй, сүүлийн гурван жилтэй харьцуулахад огцом буурсан үзүүлэлт юм. Монголбанкны мэдээлж буйгаар өнгөрсөн онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оныхоос 74 хувиар буурчээ.


Гадаадын шууд хөрөнгө оруулалт (2005-2014)




Гадаадын шууд хөрөнгө оруулалт. салбараар (1990-2013)



Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо, салбараар (1990-2014)




Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо (2005-2014)




Эх сурвалж: Монгол банк

Манай улсад хөрөнгө оруулалт хийж буй гаднын улсууд:



Хөрөнгө оруулалт салбараар



Дээрх графикаас харахад манай улсад хөрөнгө оруулж буй гаднын улсуудын ихэнх буюу 28 хувийг БНХАУ эзэлж байна. Харин БНСУ-аас орж ирэх хөрөнгө оруулалт хамгийн бага хувийг эзэлж байгаа юм.



Фотог: Б.Бямба-Очир

Тэр Монголын тухай

## Янник Кугинер: Би Монголын ЦЭЛМЭГ, ХӨХ ТЭНГЭРТ ДУРТАЙ

Д.Баяр

*“Свифт Плас” ХХК-ийн ерөнхий захирал Янник Кугинер Монгол орныг зах зээлийн харилцаанд шилжих үеэс сайн мэдэх нэгэн. Харилцаа холбоо, үүрэн телефоны салбарын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн гэж үздэг. Тэрбээр 1992 оноос хойш манай улсад ажиллаж, амьдарч буй нэгэн. Янник Кугинер Улаанбаатар хотноо “Ле Трискелл” рестораныг байгуулан ажиллаж байгаа бөгөөд монголчууд тус рестораноор үйлчлүүлэх ихэд дуртай. Учир нь анх нээгдэх үедээ хоолны амт чанар ямар байсан тэр л байдлаа хадгалж өнөөг хүрсэн, үйлчилгээний чанар, стандартыг зохих түвшинд барьж ажилладаг гэж дүгнэдэг юм билээ. Түүнтэй хийсэн Монгол орны талаарх ярилцлагыг сонирхоно уу.*

**-Таныг Монгол орныг, монголчуудыг сайн мэдэх хүн гэдэг. Таны Монголд анхлан ирсэн түүхээс яриагаа эхлэх үү.**

-Би Франц улсаас ирсэн франц хүн. Эх орондоо харилцаа холбооны “Алкател Люсент” компанид ажиллаж байхдаа дэлхийн олон орноор томилолтоор явдаг байлаа. 1992 онд Францын Засгийн газар Монгол улсын харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх зорилгоор зээл олгосноор Монголтой холбогдох үе эхэлсэн дээ. Монголын цахилгаан холбоотой хамтран Улаанбаатар хотын бүх хэсэгт анхны дижитал утасны суурилуулалт хийсэн. Намайг анхлан

Монголд ирэхэд Француу ярих гэж бүтэн өдөр шаардагддаг байж билээ. Бэрхшээлтэй асуудлууд их байсан. Улмаар харилцаа холбооны салбар хурдацтай хөгжиж, үүрэн телефоны компаниуд гарч ирсэн. Бид Мобиком корпорацийн тоног төхөөрөмжийн 80 хувийг нийлүүлсэн, мөн Юнител болон Скайтел компаниудтай гэрээтэй ажилладаг байсан. Алкател компани зөвхөн Монголд л гэхэд 400 сая еврогийн эргэлттэй ажилладаг байлаа шүү дээ.

**-Манай үүрэн телефоны салбарын хөгжлийг одоогийн өндөрлөгөөс харахад**

**танд юу бодогддог вэ?**

-Мэдээж хэрэг олон өөрчлөлт гарсан. Монголын харилцаа холбооны салбарын хөгжил Европынхтой бараг л нэг түвшинд явж байгаа. Жишээ нь төлбөрийн үйлчилгээ, хэрэглэгч нарт зориулсан программ зэрэг олон бүтээгдэхүүн Монголд хэрэгжиж байна. Мобиком, Юнител, Скайтел компаниуд сүүлийн үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр харилцаа холбооны хөгжлийн түвшинг шинэ шатанд хүргэж чадсан. Миний хувьд Монголын харилцаа холбооны салбарт хувь нэмэр оруулсандаа баяртай байдаг. Тийм ч учраас Дэд Бүтцийн сайд агсан С.Зориг харилцаа холбооны медалиар намайг шагнасан гэж боддог. Мөн Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр “Найрамдал” медалаар намайг шагнасан. Монголын ард түмэн миний Монголд хийсэн хувь нэмрийг үнэлсэн гэж ихэд баярлаж явдаг.

Өнөөгийн болон 1992 оны үеийн Монголын хооронд ялгаа асар их. Тэр үед чөлөөт цагаараа дуулах газар, их дэлгүүрүүд ховор, дэлгүүрт бараа бараг л байдаггүй, хүнд үе байж. Монгол Улс хөгжиж байгаад би их баяртай байгаа. Улаанбаатар барууны, орчин үеийн хот боллоо. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монголын Засгийн газар олон зүйлийг хийсэн, хуучин Зөвлөлтийн дэглэмээс

ардчилсан нийгэм рүү маш амжилттай шилжсэнээр хүн бүхэн бодол санаагаа илэрхийлэх эрх чөлөөтэй болсон нь том ололт.

### **-Монгол орны тухай сэтгэгдлээсээ хуваалцана уу?**

-Монголын байгаль гайхалтай. Энэхүү өргөн уудам нутгийн олон газраар явж үзсэн, очоогүй үлдсэн сайхан байгальтай газрууд ч олон бий. Манайх хотын төвөөс холгүй байшинтай. Амралтын өдрүүдээр тэр гэртээ очих их дуртай. Монголчуудын ихэнх нь Буддын шашинтай, маш сайхан соёл заншилтай улс шүү дээ.

Уламжлалаа хадгалж, үр хүүхдүүддээ үлгэрлэдэг нэг зан заншил бол Цагаан Сарын баяр. Тэртээ 1992 онд Монголд надтай хамт олон гадаад хүн ирсэн ч энэ сайхан нутагт идээшиж үлдсэн нь би юм аа. Би Улаанбаатарт өөрийн рестораныг нээж, монголчуудын дунд сайхан амьдарч байгаа хүн.

Миний хувьд далайгаа л их санадаг. Төрсөн нутаг маань далайтай их ойрхон Францын баруун хэсэгт Бриттани гэдэг газар байдаг. Их онцлогтой нутаг. Тэнд өндөр настнуудаа маш их хүндэлдэг, гэр бүлийн нэгдмэл уур амьсгал зэрэг нь монголчуудтай их төстэй. Монгол орны байгаль орчин, амгалан тайван байдал нь ижил санагддаг. Мөн түүнчлэн Сонирхуулахад төрсөн нутгийн минь ойролцоо монголчуудтай ижил дүр төрхтэй хүмүүс амьдардаг. Тэр газрын нэр нь хүртэл Марзан. Тиймээс Монгол соёл болон хүмүүс нь надад маш ойрхон санагддаг.

### **-Монгол орны хөгжлийн нэг гарц болялал жуулчлалын салбараа хөгжүүлэх хэмээн тодорхойлсон. Та юу гэж бодож байна вэ?**

-Олон франц жуулчин Монголд жил бүр ирдэг. Энэ жил ойролцоогоор 8000, өмнөх жил ойролцоогоор арваад мянган жуулчин ирсэн мэдээ бий. Аялал жуулчлал бол чухал маш их орлогын эх үүсвэр. Ийм сайхан байгаль, зан заншил, соёлтой улсад аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой. Би хувьдаа бүх л таньдаг мэддэг, найз нөхдөө Монголд ирэхийг урьдаг. Тэд маань ирээд танай сайхан оронд аялж, жуулчлаад бүгд сэтгэл хангалуун буцдаг. Миний хувьд уул уурхайн салбараа хамгийн түрүүнд, хоёрт, аялал жуулчлалын



салбараа төрийн бодлогоор дэмжиж хөгжүүлэх ёстой гэж боддог.

### **-Та манай бизнесийн орчныг хэр харж байна. Ямар бизнесийн боломжууд байна вэ?**

-Монголд бизнесийн том, жижиг олон боломж байгаа. Уул уурхайн салбараа хөгжүүлэх нь маш чухал. Оюутолгой, Тавантолгойн асуудлуудаа шийдэж, урагшлуулаасай. Гадаадын иргэн Монголд бизнес эрхлэхийн тулд зуун сая төгрөг төлдөг. Өмнө нь арван сая төгрөг байсан юм. Жижиг бизнес эрхлэхийн тулд 100 сая төгрөг төлнө гэдэг бол хэцүү, их мөнгө шүү дээ. Миний бодлоор гадаадын бизнес эрхлэгчдээс авах төлбөр, татвараа багасгах хэрэгтэй гэж бодож байна. Учир нь хэдий чинээ шинэ бизнес нээгдэнэ төдий чинээ ажлын байр Монголд бий болно. Уян хатан хандах нь бизнесийн цар хүрээг тэлдэг.

### **-“Свифт Плас” компани ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?**

-Свифт гэдэг нь түргэн шуурхай гэсэн үг. Манай компани зөвлөгөөний үйлчилгээ үзүүлдэг, тэр дундаа Монголд анх удаа ирж байгаа хууль дүрэм журмийн талаар мэдлэг бага гадаадын иргэдэд зөвлөгөө өгдөг юм. Монголд удаан хугацааны туршид амьдарсан туршлага дээрээ үндэслэн бусдад

зөвлөж тусалж байна.

### **-Таны хамгийн дуртай монгол үндэсний хоол юу вэ?**

-Ногоотой хуушуур, мөн өөх тос багатай хорхогонд дуртай.

### **-Та өөрийн эх орноо санадаг уу? Монголд амьдрахын хэцүү болон сайн тал нь юу вэ?**

-Би өөрийн охид, зээтэйгээ уулзахын тулд Франц руу ойр ойрхон явдаг учраас нутгаа бараг санадаггүй. Би Монголын цэлмэг хөх тэнгэрт дуртай. Сайхан байгальтай орон гэдгийг байнга л хэлдэг. Харин монголчууд хогоо хаа сайгүй замбараагүй хаядгаа болих хэрэгтэй байна. Манай машиныгражны үүдэнд хүртэл хог хаясан байдаг. Монголын Засгийн газариргэдээ хогны асуудалд нухацтай хандах бодлого явуулах шаардлагатай. Төрийн бодлогоор, иргэдийнхээ сэтгэхүйтэй ажиллаж байж хогноос ангижирна. Мөн машины дугаарын хязгаарлалт бага зэрэг хүндрэлтэй байдаг.

Ер нь монголчууд маш энэрэнгүй, тэвчээртэй, халамжтай хүмүүс. Буддын шашнаа шүтдэг нь таалагддаг. Би бусаад байнгатуслахыг хичээдэг хүн учраас Ротари клубт гишүүнээр элсэж, олон ажилд гар бие, сэтгэлээрээ оролцож явна. ■

## Санхүүгийн зах зээл

## Аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн зах зээлд орох сонирхлыг сэргээх шаардлага бий



*“Ард Санхүүгийн Нэгдэл”-ийн гишүүн “Ард Секюритиз” үнэт цаасны компанийн захирал А.Батболдтой ярилцлаа.*

### -Танай компани ямар чиглэлийн үйлчилгээ үзүүлж байна вэ?

-Манай компани нь 1997 онд “Батс Инвест” нэртэй үүсгэн байгуулагдсан Монголын ууган брокерийн компанийн нэг. Өдгөө 18 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд андеррайтер, брокер дилер, зөвлөхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### -Үйлчилгээний үр дүн, хамрах хүрээллийн хувьд хэр өргөжсөн бэ?

-Одоогоор 11600 гаруй харилцагчдад үнэт цаасны зах зээлийн үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд өнгөрсөн хугацаанд харилцагч компаниуддаа нийт 90 гаруй тэрбум төгрөгийн зээл, санхүүжилтийг амжилттай босгон хамтран ажилласан байна.

### -Байгууллагын бүтцийн хувьд өөрчлөлт хийгдэж байгаа гэсэн. Хийж буй шинэчлэлээсээ сонирхуулахгүй юу?

-Манай компани нь энэ оны нэгдүгээр сард Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр оноосон нэрээ “Ард Секюритиз” болгон өөрчилсөн. “Ард Санхүүгийн Нэгдэл”-ийн гишүүн компанийн

хувьд стратегийн нэгдсэн зорилтыг өмнөө тавьж, нэгдлийн нэгэн гишүүн болж хамтдаа хөгжих, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, маркетингийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, нэгдлийн бусад гишүүн компанитай харилцан ашигтай, хамтран ажиллах зорилгоор нэрээ “Ард Секюритиз” болгох шийдвэрийг гаргаж, улмаар ТУЗ болон хувьцаа эзэмшигчид санал нэгтэй дэмжсэн юм. Манай компанийн хөрөнгө оруулагч “Ард Санхүүгийн Нэгдэл” буюу “Ард Холдингс” нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа манлай компаниудад хөрөнгө оруулалт хийн, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон тэдний үнэ цэнийг дээшлүүлэх замаар өөрийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. Нэгдлийн бүрэлдэхүүнд “Ард Даатгал”, “Ард Кредит”, “Ард Актив”, “Ард Менежмент” болон “Хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан” (EIT) багтаж байна. Ардын хөрөнгө оруулалтын сангаас Техник технологийн дээд сургууль, “Номын Хишиг”, “Уайлд Дижитал Эйжэнси”, “Тэнгэр Системс” зэрэг компанид хөрөнгө оруулалт хийн удирдлагад нь идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгон ажиллаж байна.

### -Үнэт цаас, хөрөнгийн зах зээлд хэр идэвхтэй ажиллаж байна вэ?

-Монгол Улсын үнэт цаасны зах зээлд өөрийн байр суурийг байнга нэмэгдүүлж, засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлж, харилцагчийн үйлчилгээг дээдлэн ажиллахыг бид зорьж байна. Хэдийгээр Хөрөнгийн бирж дээр байдал нэг их сайнгүй байгаа ч “Ард Секюритиз” цаашид Хөрөнгийн биржийн гол тоглогч байж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмрийг оруулна гэдэгт итгэлтэй байгаа.

Хөрөнгийн зах зээлийн хувьд 2012 оны долдугаар сараас Лондонгийн Хөрөнгийн биржтэй хамтран ажиллах гэрээний дагуу “Миллениум Ай Ти” систем нэвтэрч өөрчлөлт шинэчлэлтүүд хийгдсээр байгаа ч бидний хүссэн үр дүнд хараахан хүрээгүй л байна. Үүнд эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, хууль эрх зүйн зохицуулалт, хамгийн гол нь зах зээлийн оролцогчид маань хуулиа хэрэгжүүлэх тал дээр дутагдалтай ажиллаж байгаатай холбоотой гэж бид үздэг. Мөн дурьдахгүй өнгөрч болохгүй нэг шалтгаан бол өнгөрсөн

хугацаанд үнэт цаасны зах зээл маань хөрөнгө оруулагчдын итгэлийг ихээхэн алдаж, хөрөнгийн зах зээлд итгэл алдархад хүргэсэн томоохон үйл явдлууд өрнөснийг бид мэднэ. Энэ асуудал өнөөдөр хүртэл шийдэгдээгүй л явна.

Харин өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас эхлэн Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан арилжааны банкны хүүгээс өндөр хүүтэйгээр арилжаалдаг болсноор өнөөдрийг хүртэл нийт 70 гаруй тэрбум төгрөгийн арилжааг хийж гүйцэтгэсэн байна. Түүнчлэн энэ оны хоёрдугаар сарын 16-наас эхлэн төлбөр тооцооны систем “Т+1”-рүү шилжиж байна. Нэг брокерийн компани хэд хэдэн төлбөр тооцоо гүйцэтгэх банк сонгох боломжтой болж байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтын сангууд, кастодиан банкууд бүрэн утгаараа ажиллах нөхцлийг бүрдүүлж хөрөнгийн зах зээл урагш нэг алхам ахиж, алдаа оноогоо дэнслэн яваагийн нэг хэлбэр гэж ойлгодог.

### -Салбарын цаашдын хөгжлийг хэрхэн харж байна вэ?

-Хууль эрх зүйн орчны хувьд үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013 онд батлагдсан болон “Миллениум Ай Ти” системд нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, Төлбөр тооцооны байгууллага зохицуулалтын журмуудыг гаргаж дууссанаар салбар амжилттай ажиллах бүхий л боломж нээгдсэн гэж хэлж болно. Одоо хөрөнгийн зах зээл руу орох аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг дахин сэргээх шаардлага бий. Төр засгийн зүгээс үүнийг бодлогоор дэмжиж, төрөл бүрийн хөшүүргийг хэрэгжүүлэх талаар брокер дилерийн компаниуд Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоогоор дамжуулан зохицуулагч байгууллагууд болон хууль тогтоогчдод байнга хүргэж байна. Үүн дээр бидний зүгээс болон үнэт цаасны зах зээл дээр ажилладаг маркет мейкерүүд гэгдэх брокер, андеррайтер компаниуд ажлаа улам сайн хийх хэрэгтэй. Энэ бүхэн нийлээд явбал Монгол Улсад хөрөнгийн зах зээл жинхэнэ утгаараа хөгжиж, энэ зах зээлийн боломжийг дотоодын аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчид, жирийн иргэд ч гэсэн ашиглаад явах боломжтой гэж үзэж байна. Ерөнхийдөө үнэт цаасны зах зээлийн ирээдүйг дотор нь ороод ажиллаж байгаагийн хувьд өөдрөгөөр харж байна. ■



## САР ШИНИЙН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ !

**ARD** ДААТГАЛ  
КОМПАНИ

Ердийн даатгал

**ARD** КРЕДИТ  
ББСБ

Банк бус санхүүгийн  
байгууллага

**ARD** АКТИВ  
ХЗХ

Хадгаламж зээлийн  
хоршоо

**ARD** СЕКЮРИТИЗ  
ҮЦК

Брокер, дилер, андеррайтер,  
хөрөнгө оруулалтын зөвлөх

**IET** Техник Технологийн  
Дээд сургууль

Техникийн дээд боловсрол,  
Коосэн Ахлах сургууль

Номын Хишиг

Үл хөдлөх хөрөнгийн  
түрээс

**WILD**

Вэб сайт, маркетинг,  
брэндинг хөгжүүлэлт

**TENGER**  
SYSTEMS

Санхүүгийн програм  
хангамж

**TENGER**  
FINANCIAL GROUP LLC

Санхүүгийн цогц  
үйлчилгээ

Хүчтэй. Хамтдаа.



# Даншари

DAN SHA RI

Г.Орхон

**Б**изнесээ эрүүлжүүлэх эхний алхам Даншари. Энэ үг Японд их дэлгэрчээ. Угтаа бол нүүдэлчин монголчуудын билиг ухаанаас үүдэлтэй аж. Энэ нь илүүд шунахгүй, байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх гэдэгтэй утга нэг юм. Даншари гэдэг нь “урьд өмнө нь цуглуулсан гэр доторх болон өөрийн эргэн тойронд байгаа хэрэггүй зүйлсийг хаяснаар бие сэтгэлээ хөнгөрүүлэх”

гэсэн утга агуулдаг. “Дан” гэдэг нь өөрт хэрэггүй зүйлээс татгалзах, “Шя” гэдэг нь гэрт буй хэрэггүй зүйлсийг хаях. Тэгээд “дан”, “шя” хоёрыг байнга хэрэгжүүлсний үр дүнд “Ри” буюу эд зүйлст шунах сэтгэлээс ангижирч, “Би”-д хүрэх явдал юм. Бизнес дэх Даншари гэдэг нь хэрэгцээгүй бизнесийг орхиж, дараагийн эрүүл бизнесийг хөгжүүлэх орчныг бий болгох явдал. Даншари нь

дотроо олон төрөлтэй. Бид энэ удаа Даншари гэж юу болох, үүнийг бизнестээ хэрхэн нэвтрүүлж болох, мөн нэвтрүүлэх шаардлага танд бий эсэхээ тодорхойлж болох Даншари сонжоог хүргэж байна. Харин дараагийн дугаартаа урагшаа болон ухраа Даншари гэж юу болох, эдгээрийг хэрэгжүүлэх шаардлагын талаарх сонирхолтой зөвлөгөөг хүргэх болно.

## ДАНШАРИ СОНЖОО

Тазаки Масами зохиолчийн “Бизнест хэрэгтэй даншари сэтгэлгээ” номыг 2011 онд орчуулагч М.Тэмүүлэн монгол хэлэнд хөрвүүлжээ. Уг номоос бизнестэй холбоотой сонжоог бэлтгэлээ. Мөн дараагийн хуудсанд номын танилцуулгыг сонирхуулж байна. Уншигч, бизнес эрхлэгч та доорх асуултуудад хариулж чадахгүй бол Даншари явуулах тухай нухацтай бодож үзэх хэрэгтэй.

**1. Орохыг хүсч байгаа, эсвэл үлдээхийг хүсч байгаа үйл ажиллагааны тань бизнес төлөвлөгөө бодит үндэслэлтэй болж чадсан. Хэнд ч гэсэн итгэл төрүүлэх өгөгдлүүд болон хүлээлтэд суурилсан байна уу?**

Өнгөц харахад тоо нь бодитой мэт боловч урьдач нөхцөл болоод хуумгай хүлээлт дээр суурилсан байвал тухайн тоо бодитой байж чадахгүй.

**2. Орохыг хүсч байгаа бизнес, үлдээхийг хүсч байгаа бизнес чинь санхүүгийн эрүүл байдлыг (ROA, ROE) нэмэгдүүлж, бэлэн мөнгө буюу кэш фло-**

**бий болгоход хувь нэмрээ оруулах уу?**

Компанийн үнэ цэнийг бууруулах үйл ажиллагааг дунд, урт хугацаанд үргэлжлүүлэх нь хэн бүхний хувьд ашиггүй. Хэсэг хугацаанд бол ч яахав. Дунд болон урт хугацаанд компанийн үнэ цэнийг заавал нэмэгдүүлэх үйл ажиллагаа биш бол түүнийг үргэлжлүүлэх утгагүй.

**3. Орохыг хүсч байгаа бизнес, үлдээхийг хүсч байгаа бизнес чинь компанийн богино болоод урт хугацааны зорилтыг хангахад хувь нэмрээ оруулж байна уу?**

Зорилтыг тодорхойлох асуудлыг хэлэлцэхдээ урт хугацаанд төдийгүй богино хугацаанд ямар байхыг бодохгүй бол болохгүй. Ерөнхийдөө явцгүй бизнест л энэ ажлыг “урт хугацаанд авч үзээч” гэх хүсэлт их байдаг бөгөөд ихэнх тохиолдолд энэ нь зүгээр л хугацаа сунгасан үйлдэл болдог.

**4. Орохыг хүсч байгаа бизнес, үлдээхийг хүсч байгаа бизнес чинь**

**компанийн стратегийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах уу?**

Компанийн стратегийн чанартай асуудлыг шийдвэрлэж чадахуйц байх тохиолдолд л одоо амжилтгүй яваа бизнес өөрийн хувь нэмэртэй гэж үзэж болно. Компанийн стратегид нийцэхгүй бизнест даншари хийх хэрэгтэй.

**5. Орохыг хүсч байгаа бизнес, үлдээхийг хүсч байгаа бизнес чинь ажилчдыг өөдрөг байлгаж, тэдэнд аз жаргал мэдрүүлэн, итгэл найдвар төрүүлэх үү?**

Энэ тун чухал. Одоо бага зэрэг бэрхшээлтэй байсан ч тухайн үйл ажиллагаанд шууд хамааралгүй өөр ажилчид хүртэл тэр ажилд нэгдэн орж дэмжмээр санагдах, тэдэнд мөрөөдөл, тэмүүлэл өгөх үйл ажиллагаа байх чухал. Тэгж чадахгүй тохиолдолд тухайн бизнес ажилчдын хувьд зүгээр нэг “хүнд ачаа” болчихно. ■

Номын булан

# Бизнес хэрэгтэй ДАНШАРИ СЭТГЭЛГЭЭ

Уншигч тантай шинэхэн номын танилцуулгаараа учран золголгүй хэсэг хугацааг үджээ. Бид сэтгүүлийнхээ уншигчдад шинээр хэвлэгдсэн ном бүрийг хүргэхийг зорихоос илүү таны бизнест тус хүргэхүйц, шилдэг борлуулалттай номыг танилцуулахыг зорьдог билээ. Энэ удаад өмнөх хуудсанд бизнес сонжоог нь сонирхуулсан Японы зохиолч Тазаки Масамигийн “Бизнес хэрэгтэй Даншари сэтгэлгээ” номыг танилцуулж байна.

Зохиолч Шива Рёотарогийн аян замын тэмдэглэлд монгол хүнийг “гайхалтай эд зүйлийн шуналгүй” гэсэн байдаг. “Бизнес хэрэгтэй Даншари сэтгэлгээ” номын зохиолч Тазаки Масами манай улсад таван жил амьдарч байсан байна. Тэрбээр энэ номондоо “Нээрээ ч Монголын хөдөө очиход гэр гэж нэрлэгдэх Чингис хааны үеэс өөрчлөгдөөгүй нүүдлийн зориулалттай сууцанд тэд амьдарч, багахан орон зайнд, илүү зүйлгүй аж төрдөг” гэжээ.

Түүний үзэж буйгаар монгол гэр тэр чигээрээ даншари сэтгэлгээний эх булаг аж.

Нэгэн алдартай архитекторын хэлснээр монгол гэр бол дэлхий дээрх хамгийн энгийн бөгөөд ухаалаг шийдэлтэй сууц юм. Тэрбээр байгалийн гэрлийн тусгал, агаарын урсгал зэргийг тооцоолж, илүү юм агуулаагүй нүүдлийн орон сууц. Тиймээс эд зүйлээр цөөн. Хоолны сав гэхэд үндсэндээ нэг л тогоотой байдаг. Түүн дээрээ цайгаа чанана, хоолоо ч хийнэ. Ер нь гэрт янз бүрийн зүйл тавих зай байдаггүй. Жилд гурваас дөрвөн удаа нүүж суудаг хүмүүст эд юмс цөөн байх тусмаа сайн. Гэр дотор тавих зүйлээ бодолцох ёстой болдог. Тийм болохоор онцын хэрэггүй зүйлийг хадгалж цуглуулдаггүй ард түмэн ч хэмээн онцолжээ.

Түүний үзэж буйгаар дээрх байдал үргэлжлэхээр хүн эд зүйлийн шуналгүй болдог байна. Эд зүйлийн шуналгүй

монгол хүн хүчтэй байдаг. Өөрийн эрхгүй тэд гэр бүл, байгаль дэлхий, мал аж ахуйдаа санаа тавьж, эд зүйлээр биш сэтгэлээр дүүрэн байх нь аз жаргал юм гэдгийг мэддэг байна. Нөгөөтэйгүүр эд зүйлд баригдаад ирэхээр аз жаргалын шалгуур, сэтгэл зүрхнээс эд зүйлд шилждэг гэжээ. Энэхүү номонд илүүд шунахгүй, байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх гэсэн утгатай Даншариг бизнест хэрхэн нэвтрүүлэх, үүнийг хэрэглэснээр таны бизнес хэрхэн эрүүлжих талаар өгүүлжээ. Дэлхийд алдартай “Эйпл”, “Хонда”, “Фүжицү” зэрэг компанийн амжилтын түүх, тэд бизнестээ даншарийг хэрэгжүүлснээр борлуулалт нь хэрхэн сайжирсан талаарх сонирхолтой баримтуудад тулгуурласан бизнес зөвлөмжийг уг номоос уншаарай. Таны бизнест амжилт хүсье.



Чех улсын Карлын их сургуулийн Гүн ухааны факультет Өмнөд ба Төв Азийн судлалын институтын профессор Жүгдэрийн Лувсандорж Монголын нууц товчооны орчуулгын алдааны тухай олон жилийн туршид судалж, олон хадмал бичигтэй харьцуулж үзсэний үндсэн дээр энэхүү номыг гаргажээ. Тус судалгааны бүтээл нь Монголын нууц товчооны орчуулгын, үг үсгийн олон алдааг залруулах, зөвөөр ойлгуулах төдийгүй ирээдүйн судалгаанд томоохон ач холбогдолтой хэмээн эрдэмтэд

## Монголын нууц товчооны бүрэн тайлбарт ном гарлаа

үзэж байна. Ж.Лувсандорж нь 1987 оноос Чех улсын Карлын их сургуульд багшилж байсан бөгөөд өмнө нь МУИС-ийн Монгол хэлний тэнхимд багшилж байжээ. “Монголын Нууц Товчоон” бол Монголын түүх уран зохиолын хосгүй дурсгал төдийгүй дэлхийн уран зохиолын бүрэлдэхүүн хэсэг юм. Түүнчлэн Орчин цагийн монгол хэлээр Ар, Өвөр Монголд арав гаруй удаа гадаадын 26 орны хэлээр орчуулагдан гарсан байна. Эдгээр орчуулга нь бүгд Монголын түүх уран зохиолын судлалд өөрийн хувь нэмрийг оруулсан чухал бүтээлүүд болох нь маргаангүй юм. Гэхдээ эдгээрт нэгэн хэвийн цутгамал мэт олон алдаа эндүү давтагдаж буйг профессор Жүгдэрийн

Лувсандорж харжээ. Түүний үзэж буйгаар эдгээр алдаа нь Монголын нууц товчооны хятад галиг, буруу уншилга, хадмал толины буруу орчуулгаас үүдэн гарчээ.

Нууц товчооны уг эх, уг эхийн хэл гэвэл зөвхөн уйгуржин монголоос буулгасан хятад галиг аж. Хожмын хүний хийсэн хятад хадмал, товч хятад орчуулга хоёрыг уг эхэд тооцож болохгүй юм байна. Гэтэл орчуулагчид яагаад эх монгол хэлнээс нь орчуулахгүй хятад хэлнээс орчуулдаг вэ гэсэн асуулт тавигдана. Үүнд профессор Жүгдэрийн Лувсандорж ямар хариултууд өгүүлснийг эл номоос уншаарай. ■

NEW DISCOVERY SPORT

ADVENTURE.  
IT'S IN OUR DNA.



ABOVE & BEYOND

START YOUR ADVENTURE

240 морины хүчтэй хөдөлгүүртэй  
2500 кг ачааг чирэх хүчин чадалтай  
Хурд авалт 0-100 хүртэл 8 секунд  
Шатахуун зарцуулалт 8-12 литр  
5 төрлийн шилжилттэй, 9 шатлал бүхий хурдны хайрцагтай



Вагнер Ази Автомотив ХХК

Нарны зам 55/1, Тээвэрчдийн гудамж, 14253, Сүхбаатар дүүрэг

[www.waa.mn](http://www.waa.mn)

Утас: 99108368, 99108386, 99118301, 99118375

Сар шиндээ сайхан шинэлээрэй!



Монголын шилдэг кинонуудыг хүссэн үедээ **"ВИДЕО САН"** -аас түрээслэн үзээрэй!

